



ШИНЖЭЭЧИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: МУИС-ийн Бизнесийн сургууль

Хөтөлбөрийн нэр: “Банк”

Индекс: D041203

Шинжээчийн баг:

Ахлагч: Д.Далхжав

Гишүүд: З.Оюунцацарал

Т.Уянга

Улаанбаатар хот

2019-04-10

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Товчилсон үгийн жагсаалт

БМИҮЗ	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл
МУИС	Монгол Улсын их сургууль
ОХУ	Оросын холбооны улс
УИХ	Улсын их хурал
СЭЗИС	Санхүү эдийн засгийн их сургууль
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
ХЕХ	Хөтөлбөрийн ерөнхий хороо
АСВАР	Бизнесийн сургууль, хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн зөвлөл

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	МУИС, Бизнесийн сургууль National University of Mongolia, School of Business	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	“Банк” бакалаврын зэргийн хөтөлбөр Banking	
Индекс	D041203	
Шинжээчид	<ol style="list-style-type: none"> 1. Шинжээчийн багийн ахлагч Д.Далхжав ХААИС-ийн ЭЗБС-ийн санхүүгийн тэнхмийн эрхлэгч 2. Шинжээчийн багийн гишүүн З.Оюунцацрал СЭЗИС-ийн санхүүгийн тэнхмийн эрхлэгч 3. Шинжээчийн багийн гишүүн Т.Уянга Капитрон банкны Бизнес хөгжлийн хэлтсийн Бүтээгдэхүүн хариуцсан менежер менежер 	
БМИУЗ-ийн Мэргэжилтэн	П.Оргилмаа	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2019.03.28	Мэргэжилтэн шинжээчдийн нэрсийг хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багт илгээж, ашиг сонирхлын зөрчилтэй эсэх талаар саналыг хүлээн авах
	2019.03.28	Шинжээчийн багийг томилох
	2019.03.28	Шинжээчидтэй гэрээ байгуулах
	2019.03.28	Шинжээчдэд өөрийн үнэлгээний тайланг хавсралтын хамт хүлээлгэн өгнө.
	2019.04.01	Шинжээчид тодруулах асуудлын жагсаалт гаргаж өгнө
	2019.04.02	Сургууль дээр ажиллах: Удирдлага болон өөрийн үнэлгээний багтай уулзах, Сургуулийн бэлтгэсэн материал, илрэл нотолгоотой танилцах, Сургуультай танилцах, Оюутнуудтай уулзалт хийх, Багш нартай уулзах Номын сан, лаборатори, үйлчилгээний хэсэгтэй танилцах
	2019.04.03	Сургууль дээр ажиллах: Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах, Ажил олгогчидтой уулзах, Төгсөгчидтэй уулзах, Шинжээчдийн багийн уулзалт хийх, Урьдчилсан дүгнэлтийг байгууллагад танилцуулах
	2019.04.10	Шинжээчид үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2019.04.13	Шинжээчдийн үнэлгээний тайланг сургуульд илгээж санал авна.
	2019.04.16	Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэнэ.
Хуваарьт хуралдаан	Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар шинжээчийн үнэлгээний тайланг танилцуулж шийдвэрлүүлнэ.	

Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 08 дугаар тогтоолоор батлагдсан “Боловсролын магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам, магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлагын дагуу ажиллав.
---------------------------	---

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Монгол Улсын их сургууль /МУИС/ 1957 оноос санхүүгийн мэргэжлээр дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн бөгөөд 1962 оноос банкны мэргэжлээр элсэлт авч 1966 онд анхны төгсөлтөө хийсэн байна. Энэ цаг мөчөөс эхлэн улс орны нийгэм эдийн засгийн хэрэгцээ шаардлагын дагуу сургалтын хөтөлбөртөө шинэчлэлт хийж сайжруулж ирсэн байна.

МУИС-ийн Бизнесийн сургууль сургалтын хөтөлбөрөө “Дээд боловсролын тухай хууль” болон түүнд нийцүүлэн гаргасан дүрэм журмын хүрээнд боловсруулан батлуулж, үндэсний болон олон улсын магадлан итгэмжлэлийн байгууллагуудаар удаа дараа магадлан итгэмжлүүлж иржээ. Тухайлбал 2011 онд “Менежмент банк” хөтөлбөрөө үндэсний магадлан итгэмжлэлд оруулан магадлан итгэмжлүүлж байсан бол 2013 онд бизнес удирдлагын 14 хөтөлбөрийг олон улсын магадлан итгэмжлэлийн хөндлөнгийн “ACBSP” байгууллагаар магадлан итгэмжлүүлсний нэг нь банкны мэргэжлийн хөтөлбөр байжээ.

2011 онд Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 15 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор МУИС-ийн Бизнесийн сургуульд Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургуулийг /хуучин нэрээр/ нэгтгэж банк, банкны эдийн засагч, нягтлан бодогч мэргэжлээр сургалт явуулж байгаад оноос БСШУС-ийн сайдын тоот тушаалаар батлагдсан дээд боловсролын мэргэжлийн сургалтын хөтөлбөр, мэргэжлийн индексийн дагуу “Санхүү-банк” гэсэн хөтөлбөр боловсруулан элсэлт авч банкны мэргэжилтэн бэлтгэх болсон.

Харин 2017 оноос БСШУС-ын сайдын мөн оны” А/52 тоот тушаал гарч дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөгдөх бакалаврын мэргэжлийн чиглэл /хөтөлбөрт/ индекст нэмэлт өөрчлөлт оруулсан нь “Санхүү-банк” хөтөлбөрийг “Санхүү”, “Банк” гэсэн хоёр тусгай хөтөлбөр болгон салгах үндэслэл болжээ.

МУИС-ийн Бизнесийн сургуулийн өнөөгийн хэрэгжүүлж байгаа **“Банк сургалтын хөтөлбөр нь банкны мэргэжлээр хөдөлмөрийн зах зээл дэх бодит эрэлтэд нийцсэн чадварлаг боловсон хүчин болон салбарын тэргүүлэх судлаач, мэргэжилтэн бэлтгэхэд оршино”**. Энэхүү зорилго нь Бизнесийн сургуулийн “Бид даяарших мэдлэг чадвартай манлайлагчийг бэлтгэнэ”, МУИС-ийн “Байгаль нийгэм, хүмүүнлэгийн болон технолгийн салбарт шинэ мэдлэг бүтээж, түгээн дэлгэрүүлдэг тогтвортой хөгжлийн үзэл баримтлал бүхий үндэсний их сургууль байж улс орны хөгжилд далайцтай хувь нэмэр оруулна” гэсэн эрхэм зорилгуудтай нийцэж байгаа болно. Бид үүнийг хэржүүлэхийн төлөө ажиллана хэмээн хөтөлбөрөө тодорхойлсон байна.

МУИС нь банкны чиглэлээр сургалт явуулж эхэлсэн тэр цаг үеээс өнөөг хүртэл 53 удаа төгсөлт хийж, банкны 1200 гаруй мэргэжилтэн бэлтгэсэн хамгийн их туршлагажсан дээд боловсролын сургалтын байгууллагын нэг юм.

МУИС-ийн Бизнесийн сургуулийн “Менежмент, банк” бакалаврын сургалтын хөтөлбөр нь 2011 онд дээд боловсролын үндэсний магадлан итгэмжлэлд орж эрх авч байсан бол 2016 онд эрхийн хугацаа дуусгавар болж, хоёр дахь удаагийн магадлан итгэмжлэлд орохоор өөрийн үнэлгээний тайлангаа бичиж БМИҮЗ-д ирүүлжээ.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

-Нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд хийсэн дүн шинжилгээ, ажлын төлөвлөгөө, бенчмарк, судалгааны танилцуулга /PEST, STEEP гэх мэт/

Хөтөлбөр боловсруулахдаа дэлхий нийт хүн төрөлөхтний өмнө тулгарч байгаа асуудал болох байгаль орчин уур амьсгалын өөрчлөлт, хүнсний аюулгүй байдал, цэвэр усны хомсдол, баялагийн тэнцвэрт бус байдал, санхүүгийн хямрал халдварт өвчин, террорист халдлага, үй олноор хөнөөх зэвсэг, өсөн нэмэгдэж буй эрчим хүчний хэрэглээ гэх мэт нэг улсын хүрээнээс хальсан асуудлуудыг шийдвэрлэхэд боловсрол, шинжлэх ухааны байгууллага чухал үр нөлөөтэй болохыг хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайландаа тусгасан байна.

МУИС-ийн Бизнесийн сургууль “Банк” хөтөлбөр шинээр боловсруулахдаа УИХ-аас баталсан Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Монгол Улсын төрөөс боловсролын талаар баримтлах бодлого-2024, Монгол Улсын 2016-2030 оны тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, Боловсролын үндэсний хөтөлбөр 2010-2021 он, Монгол Улсын Засгийн газраас 2016-2020 онд хөгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг баримт бичгүүдийг харгалзан үзсэн болохоо өөрийн үнэлгээний тайландаа тодорхой илтгэсэн байна.

Банк хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нь МУИС-ийн Бизнесийн сургуулийн Санхүүгийн тэнхим бөгөөд хөтөлбөр боловсруулахдаа орчин үеийн мэдээллийн технологийн хөгжил, банкны орчинд орж ирж байгаа үйлчилгээний шинэ арга хэрэгслүүд, дэвшилтэт аргуудыг таниулах, түүнийг зохистой ашиглаж чаддаг

мэргэжилтэн бэлтгэн гаргахын тулд тэнхмийн хамт олноор олон удаа хэлэлцсэн болох нь тэнхмийн хурлын тэмдэглэлүүдээр батлагдаж байна. Мөн өөрийн төгсөгчид, ажил олгогчид, Банк санхүүгийн академи, арилжааны банкуудын хүний нөөцийн албадтай хамтран ажиллаж тэдний санал хүсэлтийг хүлээн авч хөтөлбөртөө тугадаг болох нь уулзалтын тэмдэглэл, тэдэнтэй хийсэн шинжээчдийн багийн уулзалтаар нотлогдсон болно.

Хөтөлбөрөө шинэчлэн боловруулж батлуулахдаа дараах шат дамжлагын дагуу хийдэг байна. Үүнд: Хөтөлбөр шинэчлэлтийг тэнхмийн хөтөлбөрийн дэд хороогоор хэлэлцэн сайжруулаад, Бизнесийн сургуулийн хөтөлбөрийн хороогоор орж зөвшөөрөгдөөд, МУИС-ийн хөтөлбөрийн ерөнхий хороогоор орж батлагддаг байна.

-Гадаад дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулсан судалгаа, бенчмарк

МУИС нь гадаад хамтын ажиллагааны хүрээнд дэлхийн маш олон улс орнуудтай хамтарч ажиллах гэрээтэй тэдний сургалтын хөтөлбөрүүдийг өөрийн үйл ажиллагаандаа тусгадаг гэсэн тайлан мэдээлэл байна. Гэхдээ Бизнесийн сургуулийн Санхүүгийн тэнхмийн хувьд БНХАУ-ын Шанхайн Эдийн засгийн их сургууль, Полшийн Лодзын их сургууль, Японы болон ОХУ-ын зарим сургуультай хамтран ажилладаг гэрээ, санамж бичгүүд байх боловч тэдний сургалтын хөтөлбөрүүдийг авч өөрийн боловсруулсан “Банк” хөтөлбөртэй зэрэгцүүлж жишсэн, тухайн хөтөлбөрт орсон хичээлүүдийн дотоод агуулгыг судалсан судалгаа шинжилгээ дүгнэлт баримтаар олдоогүй болно.

Шалгуурыг хангасан байдал:

“Хөтөлбөрийн төлөвлөлт” 1 дэх шалгуур үзүүлэлтийн 1.1-д заасан “Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага” гэсэн дэд шалгуурыг шинжээчдийн багийн зүгээс **БҮРЭН ХАНГАСАН** гэсэн үнэлэлтийг өгч байна.

Онцлог зүйл/Туршлага:

- “Банк” хөтөлбөрөөр оюутан элсүүлэн суралцуулахдаа улс орны дотоод зах зээл дэх эрэлтийг тооцоолсон, жилд дунджаар банкны салбарт шинээр ажилд авч байгаа хүний тооцооллыг гаргасан.
- Өөрийн төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгааг жил бүр тогтмол хийдэг
- Банк санхүүгийн академи төрийн бус байгууллагатай нягт хамтын ажиллагаатай
- Банкны мэргэжилтэн бэлтгэсэн олон жилийн туршлага
- МУИС-ийн хэмжээнд үйлчилгээ үзүүлэх “Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын хэлтэс”-тэй болсон.
- Банк хөтөлбөрийн олон улсын судалгаанд үндэслэн “Олон улсын банкны үйл ажиллагаа” хичээлийг сургалтын төлөвлөгөөнд шинээр оруулсан.

Анхаарах асуудал:

- Тухайн хөтөлбөрийг сонгон суралцах оюутны тоо өнөөдөр их байх нь ажлын байр их байна гэсэн үг биш юм
- Ажлын байрны тоо хязгаарлагдмал төгссөн бүх хүн гадагш гарч мэргэжлээрээ ажиллах боломжгүй. Дээд боловсролын салбарт тэргүүлэх зэрэглэлийн загвар сургууль байх бодлогынхоо хүрээнд ирээдүйн эрэлтийг бодолцох шаардлагатай.
- Банк хөтөлбөрийг гадны өндөр хөгжилтэй улс орнуудын бүс нутагтаа тэргүүлэх зэрэглэлийн сургуулиудын ижил төстэй хөтөлбөрүүдтэй харьцуулан жишиж, сайжруулалт хийх, энэ чиглэлээр хийсэн зүйлээ нотлох баримтаар хадгалсан байх /Бенчмаркинг хийх шаардлагатай/.
- Цахим техник, мэдээллийн технологийн хурдацтай хамааралтай ойрын 10-20 жилд устаж болзошгүй мэргэжлийн жагсаалтанд банкир хэрхэн хамааралтай байх талаар судалгаа дүгнэлт хийж байх

Зөвлөмж:

- “Банк” хөтөлбөрөө тэргүүлэх хөгжилтэй улс орнуудын их дээд сургуулийн сургалтын хөтөлбөртэй зэрэгцүүлэн жишиж, шинэчлэлтийг байнга хийдэг байх
- Банкны салбарын орчин үеийн чиг хандлагыг судалж, банкинд ирээдүйд шаардлагатай боловсон хүчний судалгааг гаргаж элсэлтээ шийддэг байх,

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- *Хөтөлбөрөөр төгсөгчийн загвар*

МУИС нь бакалаврын сургалтын зорилгоо “*Бүрэн дунд боловсролтой иргэнийг нийгмийн идэвхитэй гишүүн байхад зайлшгүй шаардлагатай бүтээлч, логик сэтгэлгээтэй, санаачлагатай, шинжлэх ухаанч шийдвэр гаргадаг, нийгэм, хүмүүнлэг, байгалийн ухааны суурь мэдлэг эзэмшсэн, ёс зүйтэй, мэргэжлийн мэдлэг, ур чадвартай дээд боловсролтой иргэн болгон төлөвшүүлэхэд оршино*” хэмээн тодорхойлсон байдаг бол, Банк бакалаврын сургалтын хөтөлбөрт “*Банкны мэргэжлээр хөдөлмөрийн зах зээл дэх бодит эрэлтэд нийцсэн чадварлаг боловсон хүчин болон салбарын тэргүүлэх судлаач, мэргэжилтэн бэлтгэхэд оршино*” гэжээ. Банк сургалтын хөтөлбөрийн шинэчлэл нь МУИС-ийн алсын хараа, эрхэм зорилгыг хэрэгжүүлэхэд шууд чиглэсэн, зорилго зорилтууд нь эрхэм зорилгыг хангахуйц байдлаар томъёологдсон гэж үзэж болохоор байна. Банк хөтөлбөрийн үзэл баримтлал нь прагматик болон академик талыг оновчтой хослуулан сургалтыг

хэрэгжүүлэхдээ судалгаанд суурилсан сургалтын арга зүйг голчлохыг зорьсон байна.

Бизнесийн сургуулийн Санхүүгийн тэнхмээс жил бүр явуулдаг төгсөгчдийн ажил хөдөлмөр эрхлэлтийн судалгаанаас авч үзвэл Банк хөтөлбөрөөр төгсөгчдийн ... хувь нь төгссөн эхний 6 сар дотроо багтаж ажлын байртай болдог байна. Эндээс дүгнэхэд тус хөтөлбөрөөр төгсөгч нь нийгэмд тодорхой эрэлттэй байгааг илтгэж байна. Харин цаашдаа энэ эрэлт хэр урт удаан хугацаанд үргэлжлэхийг алс хэтийг харсан судалгаа шинжилгээгээр тодорхойлох боломжтой.

Мөн 2017 онд тус тэнхимээс арилжааны банкуудад ажиллаж байгаа 23 төгсөгчөөс хөтөлбөрөөр эзэмшүүлэх мэдлэг, ур чадварын талаар авсан судалгааг нэгтгэж үзэхэд:

- 60,9 хувь нь сургалтын агуулга чанар өнөөгийн шаардлагыг хангаж байна
- 78,3 хувь нь онолын мэдлэг хангалттай
- 70 хувь нь бакалавраар эзэмшүүлэх ур чадвар хангалттай бус
- 56 хувь нь ажлын байранд тавигдах ерөнхий дадал, ур чадвар хангагдаж байна гэсэн үнэлэмжүүд гарсан байна.

Дээрх судалгаанд дүгнэлт хийж хөтөлбөрийн хүрээнд практик ур чадварыг оюутанд эзэмшүүлэх зорилгоор дадлагыг танхимд түлхүү хийлгэхээр банкны программуудыг авч ашиглах цогц бодлого дасгал ажиллуулах гэх мэт өөрчлөлтүүдийг хийсэн байна.

- ***Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон баримт бичиг***

Олон улсын дээд боловсролын салбарт хэрэглэгдэж байгаа мэргэжлийн нэршил ангилал нэр, томъёолол, индексийн дагуу 2017 онд БСШУС-ын сайдын А/52 тоот тушаал гарч бакалаврын мэргэжлийн чиглэл /хөтөлбөрт/ индекст нэмэлт өөрчлөлт оруулсан нь “Санхүү-банк” хөтөлбөрийг “Санхүү”, “Банк” гэсэн хоёр тусгай хөтөлбөр болгон салгах үндэслэл болжээ.

МУИС-ийн Бизнесийн сургуулийн хэрэгжүүлж байгаа банк сургалтын хөтөлбөртөө ***“Банк сургалтын хөтөлбөр нь банкны мэргэжлээр хөдөлмөрийн зах зээл дэх бодит эрэлтэд нийцсэн чадварлаг боловсон хүчин болон салбарын тэргүүлэх судлаач, мэргэжилтэн бэлтгэхэд оршино”***. гэсэн зорилго дэвшүүлсэн байна. Энэхүү зорилго нь Бизнесийн сургуулийн ***“Бид даяарших мэдлэг чадвартай манлайлагчийг бэлтгэнэ”***, МУИС-ийн ***“Байгаль нийгэм, хүмүүнлэгийн болон технолгийн салбарт шинэ мэдлэг бүтээж, түгээн дэлгэрүүлдэг тогтвортой хөгжлийн үзэл баримтлал бүхий үндэсний их сургууль байж улс орны хөгжилд далайцтай хувь нэмэр оруулна”*** гэсэн эрхэм зорилгуудтай нийцэж байна. Хөтөлбөрийг санхүүгийн тэнхмийн банкны мэргэжлийн багш нарын хүрээнд боловсруулж, Бизнесийн сургуулийн хөтөлбөрийн хорооны 2018 оны хурлаар дэмжигдэн МУИС-ийн хөтөлбөрийн ерөнхий хорооны хурлаар хэлэлцэн баталжээ. Банк хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлангийн 14-18 дахь хуудаст илтгэсэн байдал, тайлангийн хавсралтууд, хөтөлбөрийн зорилго тодорхойлсон баримт

бичгүүд, хөтөлбөрөөр төгсөн гарч байгаа төгсөгчид, ажил олгогчидтой хийсэн уулзалт, тэднээс хөтөлбөрт өгч байсан санал зэрэг нь энэ хөтөлбөрт бүрэн тусч хамаарал бүхий этгээдүүдийн эрэлт хэрэгцээнд бүрэн нийцсэн гэж үзэх боломжтой.

• ***Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлох, өөрчлөлтийн талаар олон нийтэд мэдээлсэн баримт материал***

МУИС нь 1962 оноос эхлэн “Зээлийн эдийн засагч” нэртэй хөтөлбөрөөр мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн бол 2011 оноос “Менежмент-банк” нэртэй хөтөлбөрөөр, 2014 оноос “Санхүү-банк” хөтөлбөрөөр, 2018 оноос “Банк” хөтөлбөрөөр тус тус бэлтгэж байна.

Өнөөгийн банк хөтөлбөрийн өмнөх “Санхүү-банк” нэртэй хөтөлбөрийн зорилго нь **“Банк санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, удирдах, хяналт тавих чиглэлээр мэргэжлийн мэдлэг, ур чадвар бүхий мэргэжилтэн бэлтгэхэд оршино”** хэмээн тодорхойлж байжээ. Энэ зорилгоос харвал тус хөтөлбөрөөр Зөвхөн банк төдийгүй санхүүгийн бусад байгууллагуудын менежерийг бэлтгэн гаргахыг зорьж байжээ. Харин шинэчилсэн банк хөтөлбөр нь зөвхөн банкны салбарын үйл ажиллагааг дагнан эрхлэх мэдлэг, чадвар, дадал хандлага төлөвшсөн боловсон хүчин бэлтгэж байхаар томъёолсон байна.

Хөтөлбөрийн өөрчлөлт шинэчлэлтийн талаар сургуулийн дотоод SiSi мэдээллийн системээр дамжуулан багш, оюутнуудад хүргэхийн зэрэгцээ, элсэгчид зориулсан оюутны гарын авлага гаргах, МУИС –ийн болон Бизнесийн сургуулийн цахим хаягуудаар, мөн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтийн хүртээл болгодог энэ үйл ажиллагааг МУИС-ийн сургалтын бодлого зохицуулалтын алба эрхлэн гүйцэтгэдэг ажээ.

“Банк” хөтөлбөр нь МУИС-ийн эрхэм зорилго зорилттой нягт уялдаж оролцогч талуудын эрэлтэд нийцүүлсэн болох нь дараах баримт бичгүүдээр батлагдаж байна. Үүнд:

- Банк хөтөлбөрөөр төгсөгчийн эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлох судалгааны тайлан (2014, 2017 он)
- Банк хөтөлбөрөөр төгсөгчийн эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлох судалгааны excel файл (2018 он)
- МУИС-ийн сургалтын журам (МУИС-ийн захирлын 2015 оны 6 сарын 30 өдрийн А/203 тоот тушаал)
- МУИС-ийн БС-ийн хөтөлбөрийн хорооны хурлын тэмдэглэл (2018 оны 5 сарын 28-ны өдрийн №4)
- ХЕХ, бүрэлдэхүүн, салбар сургуулийн Хөтөлбөрийн хорооны бүрэлдэхүүн баталсан тушаал (МУИС-ийн захирлын 2017 оны 11 сарын 23-ны өдрийн А/370)
- Тэнхимийн хөтөлбөрийн хорооны бүрэлдэхүүнийг баталсан тушаал (БС-ийн захирлын 2017 оны 3 сарын 7 өдрийн А/20)

Шалгуурыг хангасан байдал:

“Хөтөлбөрийн төлөвлөлт” 1 дэх шалгуур үзүүлэлтийн 1.2-т заасан “Хөтөлбөрийн зорилго” гэсэн дэд шалгуурыг шинжээчийн багийн зүгээс **БҮРЭН ХАНГАСАН** гэсэн үнэлэлтийг өгч байна.

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөгчид болон ажил олгогчдоос авсан сэтгэл ханамжийн судалгааны үр дүн өндөр хувьтай
- Төгсөгчдийн 70 гаруй хувь эхний 6 сарын дотор ажлын байртай болдог ажлын байрны хангамжийн хувь өндөр
- МУИС-ийн захирлын 2015 оны 6 сарын 30 өдрийн А/203 тоот тушаалаар батлагдсан “МУИС-ийн сургалтын журам”-ын 1.10.14-д үндэслэн хичээлийн индексжүүлэлт хийсэн.
- Мэргэжлийн индекс өөрчлөгдсөнтэй холбоотойгоор сургалтын төлөвлөгөөний шинэчлэлтүүд хийгдсэн.
- Хөтөлбөрт оруулах өөрчлөлтөө тэнхимийн хөтөлбөрийн хороо, (хэлэлцсэн тэнхимийн хурлын протокол байхгүй), Бизнесийн сургуулийн хөтөлбөрийн хороогоор хэлэлцүүлж (МУИС-ийн БС-ийн хөтөлбөрийн хорооны хурлын тэмдэглэл 2018 оны 5 сарын 28-ны өдрийн №4), МУИС-ийн захирлын 2017 оны 11 сарын 23-ны өдрийн А/370 тушаалаар ХЕХ, бүрэлдэхүүн, салбар сургуулийн Хөтөлбөрийн хорооны бүрэлдэхүүн, БС-ийн захирлын 2017 оны 3 сарын 7 өдрийн А/20 тушаалаар тэнхимийн хөтөлбөрийн хорооны бүрэлдэхүүнийг тус тус баталсан.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрт хийгдсэн шинэчлэл нь зөвхөн тухайн оны элсэгч биш, өмнөх жилүүдэд хуучин хөтөлбөрөөр элссэн элсэгчдийн сургалтын төлөвлөгөөг СИСИ системд өөрчилдөг нь онцлог байлаа. Өөрөөр хэлбэл, оюутан төгсөх курстээ өөрийн анх элссэн сургалтын төлөвлөгөөгөөр бус, шинэчлэн батлагдсан сургалтын төлөвлөгөөгөөр төгсөх шаардлагатай болдог. Энэ нь оюутны хувьд 3-6 орчим кредитийн зөрүү үүсэх, нэмж судлах шаардлага үүсгэдэг. Үүнийг оюутны эрх ашигт нийцүүлэн шийдвэрлэх

Зөвлөмж:

- Хөтөлбөрөөр төгсөгчийн загварыг боловсруулах.
- Төгсөгчийн мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлох зорилгоор төгсөгч-ажил олгогчоос авсан судалгааг үндэслэн хөтөлбөрт ур чадвар, хандлагыг тасралтгүй сайжруулах, өөрчлөлт хийх.

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Батлагдсан хөтөлбөр

“Банк” сургалтын хөтөлбөрийг боловсруулахдаа Сургалтын төлөвлөгөөг Банк нэртэй D041203 мэргэжлийн индекстэй нийт 121 багц цаг байхаар төлөвлөсөн байна. Сургалтын төлөвлөгөөнд орсон хичээлийг:

- А.Ерөнхий суурь хичээл 31 багц цаг энд 9 хичээл байх бөгөөд заавал судлах
- Б. Мэргэжлийн суурь хичээл 21 багц цаг энд заавал судлах 5 хичээл сонгон судлах 2 багц буюу 5 хичээл
- В.Мэргэжлийн хичээл заавал судлах 14 хичээл 42 багц цаг байна. Сонгон судлах 2 багц тус бүр 10-11 хичээлээс 12 багц цагийг сонгон судлахаар төлөвлөгөө гаргасан байна. Хичээлийн төлөвлөгөөнд судалгаа хийхэд оюутнуудад сонгон судлах хичээлийн сонголт ихтэй давуу талтай байлаа.

Хичээл тус бүрээр олгох мэдлэг, эзэмшүүлэх ур чадвар, төлөвшүүлэх хандлагыг тодорхой гаргаж хичээл хоорондын уялдаа залгамж холбоосыг хийж өгсөн, хөтөлбөрөөр төгсөгчид тавигдах ерөнхий шаардлагыг гаргасан байна.

- Хурлын тэмдэглэл

“Банк” хөтөлбөр нь БС-ийн хөтөлбөрийн хорооны 2018 оны 05 сарын 28 ны өдрийн /04 тоот/ хурлын шийдвэр гарч зөвшөөрөгдсөн. МУИС-ийн хөтөлбөрийн ерөнхий хорооноос томилогдсон экспертизийн групп 2018 оны 04 сарын 27 ны өдөр “Банк” хөтөлбөрийн боловсруулалтанд үнэлгээ хийж дүгнэлтийн хуудсаа ирүүлсэн байна. Уг дүгнэлтээр санхүү-банк хөтөлбөрөөс ялгарах онцлог алга байна гэсэн дүгнэлт гаргасан. БС-ийн санхүүгийн тэнхмээс хариу тайлбарыг МУИС-ийн хөтөлбөрийн ерөнхий хороонд хүргүүлсэн. Энэ үндсэн дээр Банк хөтөлбөр нь МУИС-ийн хөтөлбөрийн ерөнхий хорооны 2018 оны 06 сарын 14 ны өдрийн хурлаар орж зөвшөөрөгдсөн байна

Харин “Банк” хөтөлбөрийг тэнхмийн хөтөлбөрийн хороогоор хэдэн удаа хэлэлцсэн хэн хэн ямар санал гаргасан, ажил олгогч төгсөгчөөс ирүүлсэн ямар саналыг хэрхэн тусгасан зэрэг хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлгүй. Мөн Бизнесийн сургуулийн хөтөлбөрийн хорооны хурлын тэмдэглэл, МУИС-ийн хөтөлбөрийн ерөнхий хорооны хурлын тэмдэглэлгүй харин дээрх хороодоос зөвшөөрсөн хурлын шийдвэрүүдийг олж үзсэн болно.

- Сургалтын нэгдсэн төлөвлөгөө, график /матриц/

Харин сургалтын хөтөлбөрт багтсан нийт хичээлүүдийн хоорондын уялдаа, ямар мэдлэгийг, ямар ур чадварыг, ямар хандлагыг төлөвшүүлэх, тэдгээр хичээлүүд нийлээд төгсөгчид ямар мэдлэг, чадвар, хандлагатай болгохыг нэг хавтгайд буулгаж, оюутанд төгс төгөлдөр ойлгомтой болгох талаар учир дутагдалтай байна.

- Батлагдсан хичээлийн хөтөлбөр

Сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд багтсан хичээлүүдийн хөтөлбөрүүдийг гаргаж хавсаргасан, хичээл тус бүрээр олгох мэдлэг, чадвар, дадал төлөвшлийг гаргасан аль улиралд ямар хичээлийн урьдал эсвэл үргэлжлэл болгон судлахыг тодорхой

гарасан байна. Тухайн хичээлийн бүтэц, заах багш, ашиглах сурах бичиг оюутныг үнэлэх шалгуур үнэлэмж зэргийг оновчтой тодорхойлсон байна.

Шалгуурыг хангасан байдал:

“Хөтөлбөрийн төлөвлөлт” 1 дэх шалгуур үзүүлэлтийн 1.3-т заасан “Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд” гэсэн дэд шалгуурыг шинжээчдийн багийн зүгээс **БҮРЭН ХАНГАСАН** гэсэн үнэлэлтийг өгч байна.

Онцлог зүйл/Туршлага:

- Банк хөтөлбөрийн хүрээнд 35 ур чадварыг тодорхойлж гаргасан. (Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлангийн хавсралт 110-р хуудас)

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрт орсон ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэжлийн хичээлүүдийн бүх төлөвлөгөөг бүрдүүлж, хөтөлбөрийг иж бүрэн хэмжээнд бэлтгэх
- Тухайн хөтөлбөрөөр төгсөгчийн эзэмшвэл зохих 35 ур чадварыг нэгтгэх, Хэт олон ур чадвар гаргаснаар гол ур чадваруудаа тодорхойлж чадахгүй, тарамдах асуудал үүсч болзошгүй.
- Тухайн хөтөлбөрийн өмнөх хөтөлбөрөөс ялгагдах онцлог сайжруулалт хийгдсэн гэдгийг харуулах баталгааг гаргах.
“Зээлийн шинжилгээ” хичээлийн хөтөлбөрт тухайн хичээлийн агуулгаар ямар ур чадвар олгох вэ гэдэг нь тодорхой харагдах шаардлагатай байна.

Зөвлөмж:

- Цаашид “Банк” хөтөлбөрийг дэд шалгуур тус бүрээр өгсөн зөвлөмж анхаарах асуудлын хүрээнд авч үзэж иж бүрдэл болгох
- Банк хөтөлбөрийн хүрээнд 35 ур чадварыг тодорхойлсон ч эдгээр ур чадваруудыг тус бүрт нь хэдэн төрлийн хичээлээр олгохыг тодорхойлох. Өөрөөр хэлбэл: Мэргэжилтний эзэмшвэл зохих 35 ур чадварыг хоорондоо уялдаа бүхий нэг хавтгайд буулгасан зураглал /матриц/ гаргах

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ:

Нэгдүгээр шалгуур үзүүлэлийг **БҮРЭН ХАНГАСАН** гэсэн үнэлэмжийг шинжээчдийн багийн зүгээс гаргаж байгаа болно.

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

Хичээлийн индекс, хичээлийн суралцахуйн үр дүнгийн матриц

2014 оноос МУИС-ийн хэмжээнд сургалтын хөтөлбөрийн агуулгыг шинэчлэн боловсруулж лебрал арт загварт оруулсан энэ загварын дагуу “Банк” хөтөлбөр 2018 онд “Санхүү-банк” хөтөлбөрөөс салж бие даасан хөтөлбөр болон боловсруулагдсан.

Сургалтын хөтөлбөрт орсон хичээлүүд нь “Дээд боловсролын тухай хууль”-ийн хүрээд тавигдах ерөнхий шаардлагын дагуу ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэжлийн хичээлүүд гэсэн 3 бүлэгт багцлан хуваагдаж сургалтын багц цагийн зохистой харьцааг барьсан, оюутан тухайн багцийн хүрээнд чөлөөтэй сонголт хийх боломжийг олгосон.

Сургалтын хөтөлбөр нь БСШУС-ын сайдын 2014 оны А/174 тоот тушаалаар батлагдсан “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг журам”-д нийцсэн, суралцахуйн үр дүнгийн ерөнхий матриц гараагүй хичээл тус бүрээр гаргасан.

Банк санхүүгийн академи төрийн бус байгууллагатай хамтын ажиллагааны гэрээтэй оюутны дадлагыг банкинд болон танхимд хийх гэсэн 2 чиглэл гаргасан. “Е” контент хөгжүүлэх багш нарын хамтлаг ажиллуулдаг гэх мэт давуу талууд ажиглагдаж байна.

Удирдлагын мэдээллийн систем дэх сонголтууд

Суралцагч хичээлийн жил эхлэхийн өмнөх 7 хоногт SiSi дотоод мэдээлийн системээр орж өөрийн сонгосон мэргэжлийн чиглэл-хөтөлбөрөөс судлах хичээлийнхээ агуулгатай танилцаж, хичээлийн хуваарийг үндэслэн хичээл сонголтгоо хийж, 24 цагийн дотор багтаан төлбөр хийсэн тохиолдолд сонголт баталгааждаг байна. Суралцагч тухайн улирлын төгсгөлд буюу 13-14 дэх 7 хоногт багтаан дараагийн улиралд судлах хичээлийн саналаа өгдөг байна. Банк хөтөлбөрийн тухайд сүүлийн 4 жилд нийт 129 оюутан SiSi системээр сонголт хийн суралцсан байна. Нэг хичээлийг хамгийн багадаа 2 багш заахаар төлөвлөгддөг тул оюутан наад зах нь 2 багшаас нэгийг сонгох боломжтой.

Багш нар SiSi мэдээллийн систем ашиглан лекцийн слайдууд, бие даалтын бодлого, семинарын хичээлээр ашиглах материалуудаа оюутнуудад хүргэдэг байна. Банк хөтөлбөрөөр заах хичээлүүд одоогийн байдлаар онлайн болоогүй ч бэлтгэл ажлаа хангаж баг бүрдүүлэн ажиллаж байна.

Банк хөтөлбөрөөр заагдах хичээлүүдэд дараах программуудыг ашигладаг байна. Үүнд:

- Үйлдвэрлэлийн дадлагад /Eviews, Матлаб/
- Мөнгөний бодлого хичээлд /Eviews, Матлаб/
- Банкны менежмент хичээлд /MS Office хэрэглээний программ/
- Нягтлан бодох бүртгэл хичээлд /MS Office хэрэглээний программ/
- Зээлийн шинжилгээ хичээлд /Matlab, Excel/

Эдгээр программуудийг оюутанд ажиллах боломжийг олгосон байна.

Сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд хийсэн шинжилгээ

Банк хөтөлбөрт орсон нийт хичээлүүдийг задлан авч үзвэл “Ерөнхий суурь” хичээл 9 нийтдээ 31 багц цагийн багтаамжтай заавал судлах, “Мэргэжлийн суурь” хичээл заавал судлах 5 хичээл 15 багц цаг, сонгон судлах 2 багц 5 хичээлээс оюутан 6 багц цагийг сонгон судлах боломжтой, “Мэргэшүүлэх хичээл” 54 багц цагийн багтаамжтай заавал судлах 14 хичээл 42 цагийн багтаамжтай харин сонгон судлах 2 багц 22 хичээлээс оюутан 12 багц цагийг сонгон судлах боломжтой байна. Нийтдээ төгсөгч 121 багц цаг судлах шаардлага тавигдана. Банк хөтөлбөрийн тухайд улиралд дунджаар 15 багц цаг судлах ба судлах багц цагийн доод хэмжээ 12 багц цаг дээд хэмжээ 21 ээс хэтрэх ёсгүй.

Бакалаврын сургалтын төлөвлөгөөнд тавигдах нийтлэг шаардлагатай “Банк” хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөг харьцуулан авч үзвэл:

Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага /120 багц цагаас доошгүй байна/	“Банк” хөтөлбөрийн үзүүлэлт
Үүнээс: - ерөнхий суурь хичээл нийт багц цагийн 30%-иас хэтрэхгүй байна	30 багц цаг
• Мэргэжлийн суурь: нийт багц цагийн 25%иас ихгүй байна.	21 багц цаг үүнээс заавал судлах нь 15 багц цаг
• Мэргэжлийн хичээл: нийт багц цагийн 45%-иас доошгүй байна.	54 багц цаг үүнээс чөлөөт сонголтоор 15 багц цаг
• Нийт хичээлээс чөлөөт сонголт	30 багц цаг

Дээрх харьцуулалтаас харахад хичээлийн харьцаа Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагын хэмжээнд байгаа бөгөөд оюутанд сонгон судлах хичээлийн сонголтыг нилээд өргөн хүрээтэй болгож өгсөн давуу талтай байна.

Дадлагын талаар хамтран ажиллах гэрээ, санамж бичиг, удирдамж, журам, ажлын тайлан, анализ

Оюутны үйлдвэрлэлийн болон сургалтын дадлагын ажлын удирдамжтай. Оюутны дадлагыг танхимд болон үйлдвэрлэлийн нэгжид гэсэн хоёр хэсэгт ангилан авч

үзсэн ажил олгогчдоос бие даан ажиллах чадвар, хувь хүний хандлага төлөвшлийн талаар анхаарч үзэхийг сануулсан үүний дагуу банкны зарим төрлийн програмуудыг олж танхимд дадлага хийлгэх арга хэмжээг авах болсон, “Банк санхүүгийн академи” төрийн бус байгууллага, арилжааны банкуудтай хамтран ажиллах, оюутан дадлага хийлгэх гэрээтэй ажилладаг байна.

-Хичээл хоорондын залгамж холбоог харуулсан график /хөтөлбөрийн мод/

Хичээл хоорондын уялдааг харуулсан хөтөлбөрийн мод зурсан гэхдээ 3 бүлэг хичээлийн хүрээнд хоорондын холбоосыг хийж өгөөгүй үүнээс шалтгаалан төгсөгч ямар хичээлээр ямар мэдлэг олж авах, ямар ур чадваруудыг эзэмших, ямар хандлага төлөвшүүлэх нь нэг зураглалаас харагдах боломжгүй сул талтай.

Суралцагчийн цагийн ачаалал тооцсон судалгаа

Суралцагсдын цагийн ачаалал 3-4 дүгээр ангид хэвийн гэж үзэх боломжтой. Учир нь Бизнесийн удирдлага нэртэй нэгдсэн нэг хөтөлбөрөөр оюутнууд Бизнесийн сургуульд элсч байгаа тул 1-2 дугаар ангидаа мэргэжлийн хөтөлбөрүүдэд шууд хамааралгүй. Харин мэргэжил сонголт хийсний дараа буюу 3-4 дүгээр ангидаа тухайн мэргэжлийн хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхмийн харъяалалд шилждэг. Энэ үеийн ачаалал хэвийн гэж үзэх үндэслэл өөрийн үнэлгээний тайлан хичээлийн хуваариар батлагдаж байна.

Шалгуурыг хангасан байдал:

Сургалтын үйл ажиллагаа гэсэн 2 дугаар шалгуурын 2.1 -д “Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл” гэсэн дэд шалгуур үзүүлэлтийн хүрээнд шинжээчдийн багаас **БҮРЭН ХАНГАСАН** гэсэн үнэлгээг өгч байна.

Онцлог зүйл/

- Банк болон банк бус санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээтэй.
- Банк хөтөлбөрт тусгагдсан дадлагын удирдамжийн шинэчлэлтэй холбоотой үр дүнг одоогоор харах боломжгүй.
- Санхүүгийн тэнхим нь 22 багштай бөгөөд 4 хөтөлбөрөөр мэргэжилтэн бэлтгэдэг. Багш нарын ачаалал их байдаг тул оюутантай тусгайлан цаг гаргаж ажиллах, судалгаа, шинжилгээ хийх цаг хомс байдаг (багш нартай хийсэн уулзалтын тэмдэглэл, 2019.04.02 өдрийн 15:20 цаг).

Анхаарах асуудал:

- Мэргэжлийн хөтөлбөрийн нэрээр бус Бизнес удирлага гэсэн ерөнхий хөтөлбөрөөр оюутныг элсүүлэн авч тодорхой хугацаанд суралцуулсны дараа мэргэжил сонголт хийлгэж байгаа нь элсэгчид зорьж орсон мэргэжлээ сонгох боломжийг хязгаарлаж, улмаар тэдний сурах идэвхийг бууруулах сөрөг талтай болох нь оюутны уулзалтаар илэрч байв.

- Тогтвортой нэг үзүүлэлт барьж элсэлт авдаггүй жил бүр элсэлтийн журамд өөрчлөлт оруулах нь элсэгчид сөрөг нөлөөтэй болохыг төгсөгчид болон оюутнуудтай хийх уулзалтын үед гарч байв. Энэ талаар судалгаа хийж, эерэг сөрөг талыг тооцоолох шаардлагатай.

Зөвлөмж:

- Цаашид элсэгчдийг тодорхой мэргэжлийн хөтөлбөрөөр нэр заан элсүүлэх
- Банк хөтөлбөрт орох ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэжлийн хичээлүүдийн нэгдсэн уялдааг харуулсан матриц боловсруулах.

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- *Сургалтын аргазүйг хэрэгжүүлэх загвар, заавар, зөвлөмж*

- “Дээд боловсролын тухай хууль”, БСШУС-ын яамнаас энэ чиглэлээр батласан заавар журмуудыг үндэслэн МУИС-ийн захирлын 347 тоот тушаалаар баталсан “Хөтөлбөрийн хорооны журам” Сургалтын нэгдсэн албаны даргын “Хөтөлбөр боловсруулах заавар”-ын дагуу “Банк” хөтөлбөрийн хүрээнд сургалтын арга зүйг боловсруулсан байна.
- Хөтөлбөрөөр оюутанд олгох мэдлэг, эзэмшүүлэх чадварыг монгол хүний сэтгэлгээний онцлог, орчин үеийн мэдээллийн технологийн хөгжил зэрэгт нийцүүлэн тайлбарлан ярих, үзүүлэн таниулах, харьцуулан жишүүлэх, бие даан ажиллуулах гэх мэт хэлбэрүүдийг ашигладаг байна.
- Сургалтын үйл ажиллагааг аль болох оюутан төвтэй явуулахыг зорилгоо болгодог байна. Энэ зорилгынхоо хүрээнд тонгоруу сургалтын арга хэлбэр, багаар ажиллах, кейс асуудалд суурилсан студио сургалтын арга туршлага ашигладаг байна.
- Мөн мэдээллэл харилцаа холбооны дэвшилтэд технологи, программ хангамжийг ашиглан банкны ажил гүйлгээг гүйцэтгэх, судалгаа шинжилгээ хийх, богино хэмжээний тестээр өөрийгөө сорих, дадлага хийлгэдэг, шалгах зарим тестүүдийг ухаалаг утасны Ficker программ зэргээр авах туршилтуудыг хийдэг байна.
- Оюутнуудын семинарын хичээлийн оролцоо идэвхийг сайжруулахаар “Багаар ажиллуулах”, мэтгэлцээн явуулах, таамаглал дэвшүүлэх, шинэ санаа сэдлүүд төрүүлэх зэрэг аргуудыг өргөнөөр ашигладаг байна.
- Багш хичээл заахдаа ямар нэгэн хатуу тогтоосон загвараас зайлсхийж, либериал арт хэлбэрээр явуулахыг хичээдэг байна.
- Банк хөтөлбөрөөр хичээл орж байгаа багш нарын хичээлүүд бүгд онлайн хэлбэрт шилжээгүй ч ихэнх хичээлийн лекц, семинар, кейсийн материалыг SiSi системд болон багш нар өөрсдийн вэб сайтдаа байршуулжээ.

- Төрийн мөнгөний бодлого, зээлийн шинжилгээ, банкны менежмент гэх мэт хичээлүүдийг заахдаа нийгэмд гарч байгаа банк санхүүгийн орчны өөрчлөлтүүдийг ашиглан судалгаа, шинжилгээ хийлгэх, өөрийн дүгнэлт саналаа дэвшүүлж, хоорондоо мэтгэлцэх зэрэг арга зүйг ашигладаг байна.

-Сургалтын аргазүйд хийсэн анализ судалгааны баримт материал

Өнөөгийн баримталж байгаа сургалтын арга зүй хэр оновчтой багааг оюутны санал асуулга, ажил олгогчид, мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор дүгнэж, энэ үндсэн дээр “Банк санхүү”-гийн салбарт хиймэл оюун ухаан, өгөгдлийн шинжилгээ хурдацтай хөгжиж байгаатай уялдуулан суралцагсадыг мэргэжлийн программ хангамж дээр ажиллуулах, багш нар өөрсдийн заах арга зүйн ур чадвараа энэ чиглэлд хандуулахыг зорьсон өөрчлөлтийг хийсэн байна. үүний нэг жишээ бол МУИС-ийн багшийн хөгжил, цахим сургалтын төвтэй хамтран 2017-2018 оны хичээлийн жилээс эхлэн мэргэжлийн хичээлийн агуулгуудыг цахим болон блендэд хэлбэрт шилжүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Оюутнуудад сургалтын болон үйлдвэрлэлийн дадлага хийхдээ бодит тоо мэдээлэл ашиглан Матлаб, Eviews програмууд ашиглан шинжилгээ хийж дүгнэлт гаргах ур чадварыг эзэмшүүлж байна.

Шалгуурыг хангасан байдал: Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн 2.2 дахь шалгуур үзүүлэлтэнд тавигдах шаардлагыг **Бүрэн хангасан** гэж үнэлэв.

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй буюу суралцагч сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлүүдээс СиСи програмын тусламжтайгаар хичээлээ, багшаа сонгож, хичээлийн хуваариа өөрөө боловсруулах боломжтой.
- Мэргэжлийн хичээлүүд дээр E-views, Matlab, R, R-studio програмуудыг лаборатори ангиудад суулган ашиглаж байна.

Анхаарах асуудал:

- Хичээл хоорондын залгамж холбоог сургалтын төлөвлөгөөнд уяж өгөөгүйгээс зарим тохиолдолд оюутан өмнөх уялдаа хичээлийг сонгож үзээгүйгээс болж тухайн хичээлийг сонгож чадахгүй байх тохиолдол гардаг (Оюутнуудтай хийсэн уулзалтын тэмдэглэл, 2019.04.02).

Зөвлөмж:

-

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

Сургалтад ашиглаж буй үнэлгээний аргазүйн судалгаа. /Блум таксономи, Рубрик арга г.м/

Сургалтын үйл ажиллагааны явцыг үнэлэхдээ үнэлгээний ажлын зорилгыг Блүүмийн таксономиор тогтоодог байна.

Оюутны сургалтын явцад олж авсан мэдлэг, хандлага, чадварыг **танин мэдэхүй-хувь хүний хандлага, төлөвшил-чадвар** буюу **бүтээлч үйл ажиллагаа** гэсэн үндсэн шалгуураар үнэлдэг байна.

Танин мэдэхүй: 6 түвшингөөр, хувь хүний хандлага төлөвшил 5 түвшингөөр тус тус үнэлдэг байна.

Таксономын үнэлгээний арга хэрэгсэл нь:

- Чөлөөт ярилцлага
- Асуулт хариулт
- Мэтгэлцээн
- Илтгэл тавих
- Тооцоолох
- Тест
- Бичгийн шалгалт
- Загвар боловсруулах
- Тайлан бичих гэх мэт арга хэрэгсэл ашиглан 6 түвшний үнэлэмжээр дүгнэдэг байна.

Мөн үүний зэрэгцээ МУИС-ийн сургалтын журамд заасны дагуу улирлын шалгалт, явцын шалгалт, бие даалт, дипломын ажил, төгсөлтийн хамгаалалт зэргээр шалгалтууд авагддаг байна.

Банк хөтөлбөрөөр суралцагчийн эзэмшсэн ур чадварын үнэлгээг аман хэлбэрээр үнэлэх, бичгийн хэлбэрээр үнэлэх, дадлагын хэлбэрээр үнэлэх гэсэн гурван хэлбэрийн үнэлэмгээ хийдэг байна.

Дээрхи үнэлгээний аргууддаа SWOT шинжилгээ хийж дүгнэж үзсэн байна.

Хичээл нэг бүрийн үнэлгээнд хийсэн дүн шинжилгээ, анализ /Шалгалтын хэлбэр, асуулт даалгавар, сорилын санд хийсэн шинжилгээ/

Багш бүр өөрийн заадаг хичээлийн явц, улиралын шалгалт, төгсөлтийн шалгалтын асуултуудыг бэлтгэж, тэнхим доторхи группүүдээр хэлэлцэн зөвшөөрсний үндсэн дээр тэнхимийн эрхлэгч баталгаажуулан шалгалтыг авдаг. Шалгалт авах хэлбэрийг хичээл заагч багшийн саналыг харгалзан шийдвэрлэнэ.

Шалгалтыг: аман, тестийн, төсөл бичих, тооцооллын, бодлогын, цахим программ ашиглах гэх мэт хэлбэрүүдээр авна. Жишээлбэл:

- Улирлын шалгалт нь: Тухайн хичээлийн туршид эзэмшсэн онолын мэдлэгээ танин мэдэхүйн болон практик үйл ажиллагаанд хэрэглэх чадварыг дүгнэхэд чиглэдэг.

- Явцын шалгалт нь: Тухайн хичээлийн туршид эзэмшвэл зохих мэдлэг, чадварыг олж авахын тулд хэрхэн хөдөлмөрлөж байгааг үнэлэхэд чиглэнэ.
- Миний тест нь: Ойлголт болон зарчмыг ойлгосон эсэхийг шалгах богино хугацаанд зохион байгуулах шалгалтын хэлбэр байна.
- Бие даалтын ажил нь: тухайн хичээлийг судалсан оюутан сурсан мэдлэг, чадвараа баталгаажуулах, шинэ санаа олох, багаар ажиллах чадварыг үнэлэх.
- Илтгэл тавьж хэлэлцүүлэх нь: сурсан мэдсэнээ нийгэм эдийн засгийн амьдралд судалгаа шинжилгээ хийх, дүгнэх, санал дэвшүүлэх чадварыг сорих чиглэлтэй.

Явцын болон төгсөлтийн шалгалтын журам

МУИС-ийн оюутны явцын болон төгсөлтийн шалгалтыг зохицуулсан дараах эрх зүйн актууд батлагдан гарч мөрдөгддөг байна. Үүнд:

- Бакалаврын сургалтын журам (МУИС-ийн захирлын 2015.06.30-ны өдрийн А/203 тоот тушаал)
- Дадлагын ажлын удирдамж (МУИС-ийн БС-ийн хөтөлбөрийн дэд хорооны 2017.10.27 өдрийн захирлын А/12 тоот тушаал)
- Суралцагчийн гарын авлага (хуудас 28)

Сургалтын хөтөлбөрт тусгагдсан хичээлийг судалсан оюутны олсон мэдлэг, чадварыг хичээл заагч багш хичээлийн идэвхи оролцоо, явцын шалгалт зэргийг харгалзан 70 онооны үнэлэмж өгдөг бол тухайн хичээлийн төгсгөлд хөндлөнгийн үнэлгээний шалгалтыг авч 30 хүртэл онооны үнэлгээ авдаг байна. Оюутны үнэлгээг МУИС-ийн сургалтын бодлого зохицуулалтын албанаас баталсан журамын дагуу хэрэгжүүлдэг байна.

Явцын шалгалт нь: Явцын, улирлын, бие даалтын гэсэн хэлбэрүүдтэй байдаг.

Оюутны мэдлэг чадварыг багш нар үнэлэхдээ тухайн хичээлийн үнэлгээний задаргааг харилцан адилгүй хийдэг ч явцын үнэлгээг МУИС-ийн хэмжээнд улирлын эцэс буюу 8 дахь долоо хоногт зохион байгуулахаар журамласан байна. Хичээл заагч багш суралцагчийн үнэлгээг хичээлийн улирлын төгсгөлд гаргаж SiSi системд улирлын шалгалт авснаас хойш 7 хоногийн дотор оруулах журамтай.

Төгсөлтийн шалгалт нь: МУИС-ийн сургалтын бодлого зохицуулалтын албанаас тухайн хөтөлбөрөөр судалбал зохих хичээлүүдийг судалж, багц цагийг гүйцээсэн, сургалтын төлбөрийн өргүй оюутнуудыг төгсөлтийн улсын шалгалт өгөх эрхийг нээж өгдөг бөгөөд шалгалт авах өдөр, шалгалтын комиссын бүрэлдэхүүнийг захирлын тушаалаар баталдаг байна.

Суралцагчийн сурлагын амжилт, ахицын талаарх статистик мэдээлэл, боловсруулалт, дүгнэлт /голч дүн, хичээлд унасан оюутны тоо, сурлагын амжилт, чанар гэх мэт/

Банк хөтөлбөрөөр төгсөгчдийн дүнг 2014-2018 оноор гаргаж нарийвчилсан үнэлгээ хийсэн байна.

Мөн банк хөтөлбөрөөр төгсөгчдийн он оны үнэлгээний дундаж ахиц дэвшлийг харуулсан судалгааг гарган өөрийн үнэлгээний тайлангийн 33-34 хуудсанд илтгэжээ.

**Банк хөтөлбөрөөр суралцан төгсөгчдийн сүүлийн 5 жилийн
сурлагын дундаж үзүүлэлт**

өөрийн үнэлгээний тайлан хүснэгт 2.3.2 –ээс авав/

огноо	F	D-	D	C-	C	B-	B	A-	A	НИЙТ

Төгсөгчдийн үнэлгээнээс харахад 2018 онд 23 оюутан төгссөнөөс 17,4% нь “**A**”, 65,2% нь “**B**”, 13% нь “**C**” үнэлгээтэй төгссөн байна. сурлагын чанарын үзүүлэлт өндөр байгаа нь суралцагсадын идэвхи оролцоо сайн байдгийг илтгэж байна.

Шалгуурыг хангасан байдал: Шинжээчдийн багаас “Суралцагчийн үнэлгээ” гэсэн 2.3 дахь шалгуур үзүүлэлтийг **Бүрэн хангасан** гэж үнэлэв.

Онцлог зүйл/Туршлага:

-
-

Анхаарах асуудал:

- Суралцагчийн хандлагыг үнэлдэг систем бий болгох.
- Хичээлийн нийт үнэлгээний 70 орчим хувь шалгалтаас хамаарч байна (оюутнуудтай хийсэн уулзалтын тэмдэглэл).
- Хичээлийн эхэнд шалгалт авах арга хэлбэр чиглэлийг маш тодорхой өгч байх (оюутнуудтай хийсэн уулзалтын тэмдэглэл).

Зөвлөмж:

- Шалгалтын үнэлгээний эзлэх хувь өндөр учир үнэлгээнд хөндлөнгийн үнэлгээ оруулах боломжийг судлах (оюутнуудтай хийсэн уулзалтын тэмдэглэл).

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Шинжээчдийн багаас Банк сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд тавигдах сургалтын үйл ажиллагаа гэсэн 2 дахь шалгуурын 3 шаардлагыг тус бүрд нь бүрэн хангаж байна гэсэн үнэлгээг авсан тул 2 дугаар шалгуур үзүүлэлтийг нийтэд нь **БҮРЭН ХАНГАСАН** гэсэн дүгнэлтийг гаргаж байна.

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- *Хичээлийн байр, сургалтын анги танхим, лаборатори, урлан, бие даан болон багаар ажиллах орчны хүрэлцээ, хангамж, ашиглалтын сэтгэл ханамжийн судалгааны үр дүн, хийсэн ажлын тайлан*

Улирал бүр оюутнуудаас сургалтын орчинтой холбоотой сэтгэл ханамжийн судалгаа авдаг бөгөөд цаг тухайд нь асуудлыг шийдэж өгдөг гэдэг нь оюутнуудтай болон багш нартай хийсэн уулзалтаас харагдаж байна. Мөн оюутнуудаас авсан сэтгэл ханамжийн судалгаагаар анги танхим, тохилог дулаан, гэрэлтүүлэг, агааржуулалт сайн, анги хүрэлцээтэй, хичээл давхардах тохиолдол гардаггүй, хичээлийн танхимууд сургалтын техник хэрэгсэлээр бүрэн тоноглогдсон, оюутнууд ашиглах боломжтой болох нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Харин МУИС-ийн БС-ийн байрлаж буй уг барилга нь 1957 онд ашиглалтад орсон, насжилт урттай тул дээврээс ус гоожих, эвгүй үнэр гарах зэрэг таагүй байдал үүсдэг гэсэн шүүмжийг багш, оюутнууд хэлж байв. Шинжээчдийн баг МУИС-ийн БС-ийн хичээлийн байр, сургалтын анги танхим, лаборатори зэрэг газруудаар явж танилцах үед дээрх нөхцөл байдал илэрч байв. Тус сургууль нь 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн шинэ байр барьж орчин нөхцлөө шинэчлэхээр төлөвлөсөн зураг, төсөв бүрэн шийдэгдсэн байна. Мөн Худалдаа үйлдвэрлэлийн сургууль салж тусгаарлан гарсан нь багш, оюутнуудад өрөө тасалгааны хүрэлцээ хангамж сайжирчээ.

2017-2018 оны хичээлийн жилийн 2-р улиралд сургалтын орчинтой холбоотой оюутнуудаас авсан судалгааны үр дүнгээс харахад 83 орчим хувийн үнэлгээ авсан нь сургалтын орчин хангалттай, сайжруулалт хийгдэж байгаа, сургалтын орчныг сайжруулах талаас нь богино хугацаанд арга хэмжээ авдаг гэсэн дүгнэлтийг өгч болохоор байна.

- Оюутнуудтай хийсэн уулзалтын тэмдэглэл (2019.04.02)
 - Багш нартай хийсэн уулзалтын тэмдэглэл (2019.04.02)
 - МУИС-ийн стартеги төлөвлөгөө 2016-2024
 - Оюутнуудын сэтгэл ханамжийн судалгаа 2014-2017
- *Сургалтын тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, цахим орчны ашиглалт, хүртээмж, сэтгэл ханамжийн судалгаа*

Банк хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлангийн 38-р хуудасны хүснэгт 3.1.1-д харуулсан Бизнесийн сургуулийн лаборатори ангиудтай танилцах явцад 5 лаборатори ангиас гадна хичээлийн анги танхимууд телевизээр тоноглогдсон нь багшийн хичээл заах тух, оюутны суралцах орчинд өөрчлөлт хийснийг илтгэж байна. Мөн шинжээчийн хувьд дурын нэг лаборатори ангид орж, багшийн болон оюутны кодоор СиСи систем руу нэвтэрч багшийн журнал хөтлөлт, оюутны хичээл сонголт, хичээлийн материалуудтай танилцахад системийн үйл ажиллагаа хэвийн, идэвхтэй ажиллаж байгаа нь харагдсан.

Шалгуурыг хангасан байдал:

Сургалтын орчинд тавигдах шаардлагыг **Бүрэн хангасан** гэж дүгнэв.

Онцлог зүйл/Туршлага:

- Монгол Улсын хэмжээнд загвар болсон орчин үеийн шинэ номын сантай
- Сургалтын анги танхим, лабораторийн тохижилт сайн, сүүлийн үеийн программ хангамж, тоног төхөөрөмж ашигладаг.
- Сургалтын орчны талаар “SiSi” системд хүсэлтээ оруулаад шуурхай шийдвэрлүүлж чаддаг.

Анхаарах асуудал:

- “Банк” хөтөлбөрөөр суралцагсад мэргэжлийн ном, сурах бичгийн олдоц бага, 2010 оноос хойшхи, сүүлийн үеийн сурах бичиг бараг байхгүй гэж оюутнууд шүүмжилж байлаа.
- Сургалтад ашиглаж буй програмууд лицензгүй.

Зөвлөмж:

- Сургалтын програмуудыг лицензжүүлэх тал дээр анхаарах

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

Сургалтын хэрэглэгдэхүүн, нөөцийн жагсаалт, хүртээмж, ашиглалт, сэтгэл ханамжийн судалгаа

Бизнесийн сургуулийн 2016-2024 оны стратеги төлөвлөгөөнд технологийн дэвшилд суурилсан сургалтын шинэ аргыг хэрэглэх, боловсролын онлайн болон нээлттэй эхүүдийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгыг дэвшүүлэн, уг зорилгынхоо хүрээнд сургалтад ашиглах цахим сургалтын төв байгуулах, нийт хичээлийн 1/3 –с доошгүй хэсгийг онлайн, холимог хэлбэрээр явуулах зорилтуудыг тавьж дараах ажлуудыг хийсэн байна.

Сургалтын хэрэглэгдэхүүний хувьд БС-ийн хувьд 5 лаборатори танхимыг тохижуулж, банк хөтөлбөрийн мэргэжлийн ангийн мэргэжлийн хичээлүүдэд ашиглагдах SAP ERP, SPSS 21, STATA 11, E-views 9, MS Office 2016, Power BI

Desktop, MS Project 2010, R Studio, MathLab зэрэг програмуудыг оюутнууд бүрэн ашиглах боломжтойгоор лаборатори ангиудад суулгаж өгсөн байна.

- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмж

МУИС-ийн захирлын 2015 оны 6 сарын 30-ны өдрийн А/203 тоот тушаалаар батлагдсан “МУИС-ийн сургалтын журам”-д нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг зохион байгуулдаг байна.

- Е-контент түвшинд боловсруулсан сургалтын материал

Бизнесийн сургуулийн хэмжээнд мэргэжлийн суурь болох 9 хичээлийн цахим багц хийхээр төлөвлөсний 2 хичээлийн багц бэлэн болсноос “Хувь хүний санхүү” хичээлийн Е-контенттой шинжээчийн баг танилцсан. Иж бүрэн сургалтын материал нь цахим хэлбэрээр бэлэн болсон. Цаашид Е контент бэлдэж буй багш нарыг дэмжих тодорхой бодлогыг сургуулийн захиргаанаас барьдаг болохыг багш нартай хийсэн уулзалтаас харж болохоор байлаа.

- МУИС-ийн БС-ийн хичээлийн байр, сургалтын анги танхим, лаборатори зэрэгтэй биетээр явж танилцсан байдал
- Оюутнуудтай хийсэн уулзалтын тэмдэглэл (2019.04.02)
- Багш нартай хийсэн уулзалтын тэмдэглэл (2019.04.02)
- SAP EAP болон Office 365 (2018.10.31-нд 1 жилийн хугацаатай, Queensland University Technology-тай хийсэн гэрээ)

Шалгуурыг хангасан байдал:

Е-контент түвшинд боловсруулсан сургалтын материал гэсэн энэхүү шалгуурыг

Бүрэн хангасан гэж дүгнэв.

Онцлог зүйл/Туршлага:

- ”Е” хичээл 9 байгаа багш болгон 2 хичээл Е хэлбэрт оруулсан байх шаардлага тавигдсан, 2 хичээлийг хөтөлбөрийн хүрээнд иж бүрэн онлайн болгосон зэрэг амжилтууд байна.
- Багш нар хувиараа болон хичээлийн хамтлагаараа Е-контент бүхий хичээлийн материал боловсруулахад сургуулийн зүгээс дэмждэг.
- SAP EAP болон Office 365 програмуудыг албан ёсны лицензтэйгээр ашигладаг байна.

Анхаарах асуудал:

-

Зөвлөмж:

- Цаашид лицензтэй програмуудын тоог нэмэгдүүлэх

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

Үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн жагсаалт, сэтгэл ханамжийн судалгаа.

МУИС-ийн хэмжээнд 360 мянга гаруй хэвлэмэл ном сурах сурах бичигтэй, ном сурах бичгийн хүрэлцээ хангалттай сайн. Бизнесийн сургуулийн хувьд өөрийн гэсэн номын сантай, 9000 гаруй монгол, 6000 гаруй англи, 100 гаруй орос ном сурах бичигтэй хэдий ч түүн дотроо банк хөтөлбөрийн хувьд мэргэжлийн ном сурах бичгийн хангалт төдийлөн сайн биш болох нь багш, оюутнуудтай хийсэн уулзалтаар илэрч байлаа. Шинжээчийн багийн МУИС-ийн хичээлийн 5-р байранд байрлах номын сангийн үйл ажиллагаатай танилцах явцад дээрх байдал харагдаж байлаа.

-Мэргэжлийн ном, сурах бичгийн баяжилт, шинэчлэлтийн судалгаа

Банк хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланд тусгаснаар санхүүгийн тэнхимийн хувьд 6 жилийн байдлаар жил бүр номын бүрдүүлэлт хийж, 2018 оны жилийн эцсийн байдлаар 2 төрлийн 15 ширхэг номонд 3.3 сая төгрөг зарцуулсан байна. Эндээс жил ирэх тусам ном бүрдүүлэлтэд хийсэн хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаа нь харагдаж байна. Гэхдээ банк хөтөлбөрийн хувьд мэргэжлийн ном сурах бичгийн судалгааг салгаж харвал арай өөр үр дүн гарахаар харагдаж байна.

-Цахим мэдээллийн сан, нээлттэй эх үүсвэрийн ашиглалтын судалгаа.

Num.edu.mn сайтаар нэвтэрч МУИС-ийн хэмжээнд ашиглагдаж байгаа цахим мэдээллийн сан, нээлттэй эх үүсвэрийн мэдээлэлтэй танилцахад дараах эх сурвалжуудыг оюутнууд бүрэн ашиглах боломжтой байна. Үүнд:

- EBSCO
- JSTOR
- ROYAL SOCIETY
- ANNUAL REVIEW
- The proceedings of the national academy of science of the USA
- SPIE DIGITAL LIBRARY
- THE GEOLOGICAL SOCIETY OF LONDON
- SAGE PUBLISHIER
- SPRINGER
- ESA JOURNALS
 - МУИС-ийн БС-ийн хичээлийн байр, сургалтын анги танхим, лаборатори зэрэгтэй биеэр явж танилцсан байдал
 - Оюутнуудтай хийсэн уулзалтын тэмдэглэл (2019.04.02)
 - Багш нартай хийсэн уулзалтын тэмдэглэл (2019.04.02)
 - МУИС-ийн стартеги төлөвлөгөө 2016-2024
 - Оюутнуудын сэтгэл ханамжийн судалгаа 2014-2017

Шалгуурыг хангасан байдал:

Цахим мэдээллийн сан, нээлттэй эх үүсвэрийн ашиглалт гэсэн шалгуурыг **Бүрэн хангасан** гэж дүгнэв.

Онцлог зүйл/Туршлага:

•

Анхаарах асуудал:

- Банкны мэргэжлийн хөтөлбөрийн мэргэжлийн ном, сурах бичгийн олдоц бага, 2010 оноос хойшхи, сүүлийн үеийн сурах бичиг ховор байгааг анхаарах.
- Бизнесийн сургуулийн номын сан 80 хүний суудалтай ч ачаалал их, чимээ шуугиан ихтэй, оюутан даалгавар хийгээд суухад тухгүй заавал төв номын сан явах шаардлага үүсдэг, тэр хооронд цаг хугацаа алддаг гэсэн санал шүүмжлэлийг анхаарах.
- Сургалтанд лицензгүй программууд ашиглаж буй нь эрсдэлтэйг бодолцох

Зөвлөмж:

•

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ:

Гуравдугаар шалгуур үзүүлэлтэнд тавигдах шаардлагуудыг төрөл тус бүрд нь бүрэн хангаж байгаа тул **БҮРЭН ХАНГАСАН** гэж үнэлэв.

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- *Хөтөлбөрийн хороо, профессорын баг, тэнхимийн хурлын шийдвэр, тэмдэглэл*

Тэнхим нь хөтөлбөр, сургалтын үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргахдаа тэнхимийн багш нараар хэлэлцүүлэн саналыг тусгадаг бөгөөд хөтөлбөртэй холбоотой өөрчлөлт, шинэчлэлтийг хийхдээ тэнхимийн хөтөлбөрийн хороо хэлэлцэн холбогдох үндсэн хороодод асуудлыг уламжлан шийдвэрлүүлдэг байна. Энэ үйл ажиллагаа нь дараах журмаар зохицуулагдаж байна.

- МУИС-ийн захирлын 2016 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/347 дугаар тушаалаар Хөтөлбөрийн хорооны журам батлагдсан. Энэхүү журмыг мөрдлөг болгон ажилладаг.

- Мөн 2017 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/20 дугаар тушаалаар тэнхимийн хөтөлбөрийн хороо байгуулагдсан. Тэнхимийн хөтөлбөрийн хороо дотроо 3 ундсэн хэсэгт хуваагддаг. Санхүүгийн, банкны, даатгалын гэсэн чиглэлтэй. Албан бус профессорын баг ажилладаг.
- Санхүүгийн тэнхимийн хөтөлбөрийн дээрхи хороодоор сүүлийн 3 жилд гарсан санал гомдолыг 6 бүлэгт хуваан авч үзэж хэлэлцэн шийдвэрлэсэн байна. /Өөрийн үнэлгээний тайлан 51 дүгээр хуудас/
- 2017 оны 11 дугаар сарын 23-ны өдрийн А/370 дугаар тушаалаар Хөтөлбөрийн хороодын бүрэлдэхүүн батлагдсан.
- **Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой эрхзүйн баримт бичиг, эрхзүйн баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ**
 - Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой эрх зүйн баримт бичиг болох дүрэм, журмын тухай мэдээллийг Өөрийн үнэлгээний тайланд /хуудас 48/ бичсэн.
 - Сүүлийн 5 жилд Хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбоотой БСШУС-ийн сайдын болон МУИС-ийн болон Бизнесийн сургуулийн захирлын нийт 9 журам батлагдан гарсан, мөрдөгдөж байна.

Эдгээр нь сургалтын хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэхэд мөрддөг нийтлэг дүрэм, журмууд бөгөөд Бизнесийн сургууль хөтөлбөрийн аливаа үйл ажиллагаа, харилцааг дээрх хууль, дүрэм, журмын хүрээнд зохицуулдаг болохыг харуулж байна.

- **Хөтөлбөрт ирсэн санал гомдол, шийдвэрлэлтийн тайлан**
 - Хөтөлбөрт ирсэн санал гомдлыг тэнхим, хөтөлбөрийн хурлаар тухай бүр шийдвэрлэдэг нь Тэнхимийн хурлын тэмдэглэл хавтас дахь баримтаар нотлогдсон. Мөн Sisi.num.edu.mn цахим хуудсаар багш нарын хичээл зааж буй чанар, зан харилцааны талаар 2 удаа оюутнуудаас санал хүсэлтийг авч холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлдэг нь маш шуурхай үйлчилгээ юм.
 - МУИС-ийн хэмжээнд SiSi системээр багш нарын хичээл зааж буй чанар, зан харилцааны талаарх судалгааг жилд 2 удаа оюутнуудаас авдаг бөгөөд багш нар түүнд үндэслэн дүгнэлт хийж, сургалт, заах арга зүйгээ байнга сайжруулахад анхаарч ажиллах боломжийг бүрдүүлсэн байна.
- **Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн урт, дунд, богино хугацааны тайлан, төлөвлөгөө.**
 - МУИС-ийн захирлын 2016 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн А/138 дугаар тушаалын 7 дугаар хавсралтаар Бизнесийн сургуулийн хэрэгжүүлэх төлөвлөгөө батлагдсан. Бизнесийн сургуулийн хэрэгжүүлэх төлөвлөгөө нь МУИС-ийг 2016-2024 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөөний нэг хэсэг болж байна.

- Энэ төлөвлөгөөний хүрээнд тэнхимийн хөтөлбөрийн хороод хуралдаж, хичээлийн жилийн ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хэлэлцэж багш нар өөрийн үнэлгээний тайлангаа тавьж хэлэлцүүлдэг бол оюутнуудаас тэдний заах арга зүй хичээлийн чанар үр нөлөөний талаар санал асуулга авч нэгтгэдэг байна. Мөн үүнээс гадна тэнхим 7 хоног бүр шуурхай зөвөлгөөн хийж тухайн 7 хоногийн ажлуудыг дүгнэн хэлэлцдэг байна.
- **Тайлан төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ**
 - Төлөвлөгөөний эхний 3 жилийн хэрэгжилтийг үнэлэх ажлын хэсэг МУИС-ийн захирлын 2019 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/77 дугаар тушаалаар батлагдсан бөгөөд гүйцэтгэлийг тэнхимийн хурлаар хэлэлцдэг болох нь Тэнхимийн хурлын тэмдэглэл хавтас дахь тэмдэглэлээр нотлогдож байна.
 - 2018 оны 12 дугаар сард МУИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудын захирлууд, тэнхим, нэгж, албаны түвшинд үр дүнгийн гэрээг дүгнэж тухайн жилийн гүйцэтгэлийг үзүүлэлт тус бүрээр хэлэлцсэн.
- **Сургалтын удирдлага, мэдээллийн системийн ашиглалт, хяналт, ил тод байдалд хийсэн дүн шинжилгээ.**
 - МУИС-ийн оюутан суралцагчид тодорхойлолт олгох зориулалттай ТҮЦ машиныг ашиглах журмыг 2014.12.30 Захирлын тушаал №А/422 дугаар тушаалаар баталсан.

Шалгуурыг хангасан байдал:

Энэхүү шалгуур үзүүлэлтэнд тавигдах шаардлагыг **Бүрэн хангасан** гэж дүгнэв.

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн хороо нь доороос дээш чиглэсэн босоо тогтолцоотой байгаа нь багш, тэнхим, сургуулийн саналыг бүрэн тусгах боломжийг хангасан. Профессорын баг, хороо нь чадварлаг бүрэлдэхүүнтэй. Сургуулийн дүрэмд заасны дагуу үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг.
- Аливаа хөтөлбөртэй холбоотой асуудал шийдвэрлэхдээ тус асуудалд хамаарах этгээдээс /Оюутан, багш, төгсөгч, ажил олгогч/ санал, сэтгэгдэл авч хэвшсэн.
- Хөтөлбөрийн төлөвлөгөө нь сургуулийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдсан.
- Санал гомдол хүлээн авч шийдвэрлэдэг тогтолцоотой. Аман, бичгэн, цахим, хэлэлцүүлэг гээд олон талт хэлбэрээр авч шийдвэрлэдэг. Үр дүнг үнэлдэг.
- Тус сургууль нь мэдээллийн ил тод байдлыг хангасан СиСи системийг нэвтрүүлсэн бөгөөд тус цахим хуудсаар санал асуулга, багш нарын үнэлгээ зэрэг мэдээллийг нээлттэй мэдээлдэг.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн 3 хороотой бөгөөд шат бүр дээр хугацаа алдах, зарим санал тусахгүй байх зэрэг бэрхшээл үүсч байгааг анхаарч ажиллах

Зөвлөмж:

- Мэдээллийн SiSi системийг илүү өргөн, бүрэн хүчин чадлаар нь бүх давуу талыг ашиглаж ажиллах
- Оролцогч талуудын саналыг авсан талаараа тоо баримт бүрдүүлэх, эргэж мэдээлэх

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

-Хэрэгжүүлж буй хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийн гэрээ, хэлцэл, ажлын тайлан

- Санхүүгийн тэнхимийн хамтын ажиллагааны чиглэлээр дотоодын байгууллагуудтай байгуулсан гэрээ, санамж бичгийн жагсаалт Өөрийн үнэлгээний тайлангийн хавсралт 4.2.4-т байсан бөгөөд газар дээр ажиллахад байгуулагдсан гэрээг хавтасласан баримт бичгээр нотлогдсон. Банк хөтөлбөрийн хүрээнд 21 байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг байгуулсан байна.
- Хамтын ажиллагааны гэрээ байгуулах тухай 2018.04.11-ний өдрийн Захирлын №А/108 тушаалаар батлагдсан журам хэрэгжүүлдэг байна.
- Сүүлийн 5 жилд банкны чиглэлээр гадаадын хамтарсан хөтөлбөр хэрэгжээгүй, санхүүгийн бусад чиглэлүүдээр гадаадын тухайлбал, ОХУ-ын Эрхүүгийн их сургуулийн профессоруудтай хамтарсан төсөл хэрэгжүүлсэн. Мөн БНПУ-ын Лодзын их сургуультай санхүү, банкны мэргэжлээр 22 бакалаврын хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг эхлүүлжээ.

Багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсдын тоон судалгаа, дүрэм журам

- МУИС-д суралцагчдад тэтгэлэг олгох нийтлэг журам, 2018.10.20 Захирлын №А/405 дугаар тушаал гарсан.
- Багш солилцооны ажлын хүрээнд Банк Г.Гүнбилэг АНУ-ын Минсота мужын Сайнт Томасын Их Сургуульд зуны улиралд багш солилцоогоор туршлага судлаад ирсэн байна. Ажлын тайланг 2018 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн тэнхимийн хурлаар хэлэлцүүлсэн.
- Тус тэнхим нь 2016 оноос ОХУ-ын Байгалийн их сургууль, 2017 оноос БНПУ-ийн Лодзын их сургууль, 2018 оноос Өвөр Монголын үндэсний их сургууль, БНХАУ-ын Шанхайн их сургуулиудтай гэрээ байгуулж

багш, оюутан солилцоо болон хамтарсан судалгаа төсөл хэрэгжүүлэх чиглэлээр хамтын ажиллагаагаа эхлүүлээд байна.

-Нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хэлбэр, хамрагдагсдын тоо, үр дүн, ажлын тайлан, дүгнэлт /багш, суралцагчдын зүгээс/

- Банкны хөтөлбөрөөр суралцагч оюутнуудыг Банк санхүүгийн академитай хамтран “Шинэ үеийн банкир” төслийг зохион байгуулдаг байна.
- Банк хөтөлбөрийн багш нар 2013-2018 онд хамтран хэрэгжүүлсэн гэрээт ажлуудыг тэнхмийн хэмжээнд улирал жилийн эцэст нэгэтгэн тэнхмийн болон сургуулийн захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэн дүгнэдэг байна. Мөн Бизнес консалтинг төвтэй хамтран төгсөгчдийг давтан сургах, өмнө хэрэгжүүлж байсан богино хугацааны сургалтын модулиудыг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж байна.

-Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны баримт материал

- Төгсөгчдийн эргэх холбоотой байхад чиглэсэн төгсөгчдийн нэгдсэн цахим хуудастай бөгөөд тухайн хуудсаар дамжуулан ажил эрхлэлтийн мэдээлэл авах, аливаа төгсөлтийн дараах мэдээлэл солилцож арга хэмжээ авдаг. Мөн төгсөгчдийн чанар, сургалтын хөтөлбөрт оруулах өөрчлөлтийн талаар ажил олгогчдоос санал авч хөтөлбөрт тогтмол өөрчлөлт хийж ирсэн байна. Төгсөгчидтэй хийсэн уулзалтаар баталгаажуулав.

-Төгсөгчдийг давтан сургалтад хамруулсан талаарх тоон мэдээлэл

- Төгсөгчдийг давтан сургалтад хамрагдах талаар баримтлах бодлоготой бөгөөд 2015.06.30-ны өдрийн Захирлын №А/203 дугаар тушаалаар батлагдсан МУИС-ийн Сургалтын журамд зааж өгсөн. Цаашид төгсөгчдийн сургалтыг тогтмолжуулах зорилгоор Банк санхүүгийн академитай хамтран ажиллах санамж бичиг байгуулж, хичээлийн жил бүр хийх ажлын төлөвлөгөө гарган гэрээний хэрэгжилтийг дүгнэн ажилладаг байна.
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь оролцогч талууд, төгсөгчид, төгсөгчдийн холбооны санал, судалгаанд үндэслэн төгсөгчдөд тавигдах шаардлагад сургалтын хөтөлбөрийг нийцүүлэх, судалгаа эрдэм шинжилгээний ажлын үр, багшийн хөгжил, төлөвлөгөө хөтөлбөрүүдэд тодорхой хэмжээгээр тусгалаа олж сайжруулсаар ирсэн байна.

Шалгуурыг хангасан байдал:

Хамтын ажиллагаа нийгэмд үзүүлэх үйлчилгээ гэсэн энэхүү шалгуур үзүүлэлтийг **Бүрэн хангасан** гэж дүгнэв.

Онцлог зүйл/Туршлага:

- Банк санхүүгийн олон байгууллагатай хамтран ажиллаж олон арга хэмжээ зохион байгуулдаг нь тус хөтөлбөрийн төгсөгчдийн 97%-ийг ажлын байраар хангахад нөлөөлдөг.
- Багш, оюутны солилцоо, тэтгэлэгт хөтөлбөр, сургалт семинарт оролцох, хамруулах боломжийг эрх зүйн хувьд бүрэн бүрдүүлсэн.
- Төгсөгчдөд тавих шаардлагад сургалтыг нийцүүлэх чиглэлд Төгсөгчдийн холбооны саналыг авдаг.

Анхаарах асуудал:

- Хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлж буй боловч банк руу чиглэсэн хөтөлбөр хэрэгжээгүй.

Зөвлөмж:

- Олон байгууллагатай хамтран ажиллаж байгаа ч гэрээ дүгнэж үр дүнг хэлэлцдэггүй тул гэрээ дүгнэх арга хэмжээг товлож зохион байгуулах
- Гадагшаа чиглэсэн хамтын ажиллагааг өргөжүүлэх

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

-Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн жилийн төсөв, зарцуулалтын тайлан

- Тэнхмүүдийн төсөв нэгтгэгдэн сургуулийн төсөв зохиогддог. Бүрэлдэхүүн сургуулиудын төсөв нэгтгэгдэн МУИС-ийн төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцэгдэн төсөв батлагддаг байна. Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь сургуулийн орлого зарлагын төсөв батлах үеэр өөрийн санал хүсэлтээ хүргүүлдэг ч зарим үе тэр бүр санасан хэмжээнд зохицуулагдаж чаддаггүй байна. Мэргэжлийн тэнхмүүдийн тухайд тусгайлсан орлого, зарлагын төлөвлөгөөгүй төсвийг гардан зарцуулах эрхгүй байдаг.
- Өөрийн үнэлгээний тайланд сүүлийн таван жилээр /хуудас 55/ төсөв, зарцуулалтын тайланг оруулсныг шинжээчийг баг ажиллах үеэр санхүүгийн тайлантай тулган баталгаажууллаа.

-Нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоо

- Сургалтын төлбөрийн багц цагийн үнэлгээний өөрчлөлт хийгдэх бүрт Удирдах зөвлөлийн тогтоол гардаг. Тухайлбал 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 06 дугаар тогтоолоор Сургалтын төлбөр, дотуур

байрны үйлчилгээний төлбөр, үйлчилгээний бусад хураамжийг нэмэгдүүлэх тухай тогтоол гарсан байна.

- 2016 оноос тус хөтөлбөрийн 1 багц цагийн төлбөр 30 орчим хувиар өссөн байна. Улирлын суурь хураамж харьцангуй тогтвортой буюу сүүлийн 5 жилд 10% нэмэгдсэн байна.
- Хөтөлбөрийн нэгжээс ирүүлсэн өөрийн үнэлгээний тайланд тусгаснаар Нэг суралцагчид ногдох өртөг зардал дунджаар 1.4 сая төгрөг байна. Энэ үзүүлэлт бол нийт сургуулийн дундаж учраас тухайн хөтөлбөр тус бүрдээ өөр өөр байх нь ойлгомжтой юм.

-Сургалтын төлбөрөөс хөтөлбөрт зарцуулагддаг хувь хэмжээ, үр дүнгийн судалгаа 50 орчим хувь байна.

- Хөтөлбөрийн сургалтын төлбөрийн орлого сүүлийн 5 жилийн байдлаар авч үзвэл 194,1-1293,8 сая төгрөг байна. Хөтөлбөртэй холбогдож гарсан зардал нь 163,2-658,2 сая төгрөг байгаагаас үзвэл хөтөлбөрт зарцуулагдах зардал 84,0-50,8 хувьтай байна. Дараах хүснэгтээр харуулав

Банкны менежмент хөтөлбөрийн орлого зардал /201-2017 он/ сая төгрөгөөр

Он	2013	2014	2015	2016	2017
Хөтөлбөрөөр орох орлого	194,1	287,7	239,8	156,2	1293,8
Хөтөлбөрийн зардал	163,2	206,2	144,6	94,4	658,2
Цэвэр орлого	30,9	81,5	95,3	61,7	635,7

Нийт зардалд шууд зардлын эзлэх хувь дунджаар 50,0-иас дээш хувьтай байгаа нь хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх боломжтой байгааг харуулж байна.

-Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв, төсвийн зарцуулалт

- 2016.05.26-ны өдрийн А/138 дугаар захирлын тушаалаар батлагдсан МУИС-ийн 2016-2024 оны стратеги төлөвлөгөөний 07 дугаар хавсралтаар Бизнесийн сургуулийн төлөвлөгөө батлагдсан бөгөөд түүнд түүний 4.2 дахь заалтаар олон талт санхүүгийн эх үүсвэртэй болох зорилт тавин ажилласнаар 2017 оны байдлаар төсвийн нийт орлогод бусад орлогын эзлэх хэмжээ 10 орчим хувь болж өсөх хандлага ажиглагдаж байна.
- Бусад ологод гол нөлөө үзүүлж байгаа нэг хүчин зүйл бол 2005 оноос Бизнесийн сургуулийн дэргэд ажиллаж байгаа Бизнес консалтинг үйлчилгээний төв юм. Тус төв нь сертификаттай түр сургалтыг голлон зохион байгуулж түүнээс орох орлогыг сургуулийн төсөвт оруулж ирсэн байна. /Өөрийн үнэлгээний тайлангийн 58 хуудас/
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд хамгийн их нөлөөлөх хүчин зүйл бол багшийн хөгжил. Үүнтэй холбоотойгоор тус хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж багшийн хөгжлийг дэмжихтэй холбоотой дэмжлэг үзүүлэхэд анхаарч ажилласан нь

сүүлийн 3 жилд сургалт, семинарын зардал 44.9 сая төгрөгөөс 124.4 сая төгрөг болсноос харагдаж байна.

-Төр, хувийн хэвшлийн дэмжлэг, санхүү түүний зарцуулалтын тайлан

- Улсын төсвөөс гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир ус төрлийн зардлууд дээр татаас авдаг бөгөөд нийт зардалд эзлэх хувийн дунджаар 2.5 хувийг эзэлж байна.
- Сүүлийн 5 жилийн байдлаар улсаас авсан татаасын 49%-ийг гэрэл, цахилгаанд, 14%-ийг цэвэр, бохир усны зардалд, 36%-ийг дулааны зардалд тус тус зарцуулсан байна.
- Хувийн хэвшлийн дэмжлэг нь ихэнхдээ эрдэм шинжилгээний хурал, практик дадал олгох сургалт зэргийг ивээн тэтгэх, хамтран зохион байгуулах чиглэлтэй байна.

Шалгуурыг хангасан байдал:

Энэхүү шалгуур үзүүлэлтийг **Бүрэн хангасан** гэж дүгнэв.

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн хувьд орлого нь харьцангуй тогтвортой, ирээдүйн төсөөлөл хийхэд тохиромжтой.
- Нийт зардалд эзлэх шууд зардлын хувь өндөр буюу сургалт руу чиглэсэн бүтэцтэй.
- Багшийн хөгжилд ихээхэн анхаардаг санхүүгийн үзүүлэлттэй нь шууд харагдаж байна.

Анхаарах асуудал:

- Зардлын хувьд Бизнесийн сургуулийн зардлаас банк суралцагчийн зардлыг салган тооцоход хүндрэлтэй.

Зөвлөмж:

- Сургуулийн стратеги төлөвлөгөөний 4.2 дахь зорилтыг хангаж ажиллах чиглэлд багш нарын эрдэм шинжилгээний ажил, бүтээлээс олох орлогыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

-Тандан судалгаа, дүгнэлт, холбогдох материал

- SiSi системээр дамжуулан оюутнуудаас сэтгэл ханамжийн судалгаа авдаг. Энэ нь бааз дээр архивлагддаг.
- Хөтөлбөр сурталчлах, тандах ажлыг сургууль дээр дотооддоо болон гадны байгууллагуудтай хамтран хэрэгжүүлдэг. Энэ нь өөрийн үнэлгээний

тайлангийн 59-р хуудаст бичигдсэн бөгөөд тэнхмийн хурлын тэмдэглэл хавтас болон хамтын ажиллагаа хавтаст байсан баримтуудаар нотлогдсон.

-Хийсэн ажил, арга хэмжээ, тайлан, баримт

- Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлтийг гадагш болон дотогш чиглэсэн 2 урсгалаар явуулдаг бөгөөд жил бүр Бизнесийн сургуулийн захирлын тушаалаар Банк, санхүүгийн хөтөлбөр сурталчлах удирдамж батлуулан ажилладаг. Хавар ЕБС-руу чиглэсэн болон төгсөгчдөд чиглэсэн ажлын байрны өдөрлөг, намар элсэгчид рүү чиглэсэн хөтөлбөр сурталчилгаа хийдэг.
- Жил бүр Элсэгчийн, Суралцагчийн, Мэргэжлийн хөтөлбөрийн танилцуулга гарын авлагуудыг хэвлүүлж олон нийтийн хүртээл болгодог.

Шалгуурыг хангасан байдал:

Энэ шалгуурт тавигдах шаардлагыг **Бүрэн хангасан** гэж дүгнэв.

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөгчдөд тавигдах шаардлага нь ажил олгогчийн хувьд нийцэж буй эсэхэд судалгаа авч сайжруулж байна.
- Хөтөлбөрийн сурталчилгааг элсэгч, оюутнуудад чиглэсэн олон сувгаар тогтмол хийж байна.

Анхаарах асуудал:

- Дотоодын судалгаа болон хөдөлмөрийн зах зээлийн судалгааны үр дүн уялдаа багатай.

Зөвлөмж:

- Төгсөгчдөөс санал асуулга авдаг боловч эргэн мэдээлдэг сувгийг бүрдүүлэх

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжээс гаргасан сонин, сэтгүүл, ном товхимол гарын авлага, цахим мэдээллийн жагсаалт

-Вебсайтын мэдээллийн иж бүрэн байдал, тогтмол ажиллагаа

- Үүс сургууль нь www.num.edu.mn цахим хуудастай бөгөөд элсэгч, оюутан суралцагч, багш, тэнхим зэрэг бүгдийг хамарсан иж бүрэн хэсгүүдтэй. Үйл ажиллагаа нь тогтмол, байнгын шинэчлэлттэй явагдаж байна. 2017 онд давхардсан тоогоор 707.0 мянган удаа хандсан байна. Банк, санхүүгийн

тэнхимийн хувьд www.bs.num.edu.mn цахим хуудастай бөгөөд 2005 оноос ажиллуулж эхэлсэн ба 2011 оноос үндсэн цахим хуудсаар холбогдох мэдээллийг өгч байгаад 2017 оноос ахин биеэ даасан хэлбэрээр явуулж байна.

Шалгуурыг хангасан байдал:

Энэхүү шалгуур үзүүлэлтэнд тавигдах шаардлагыг **Бүрэн хангасан** гэж дүгнэв.

Мэдээллийн системийн ашиглалт, хэрэглээ сайн. Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг авч сайжруулалтыг хийдэг.

- Сургуулийн веб сайтын бүтэц бүрэн мэдээллийг агуулсан, ашиглахад ойлгомжтой бүтэцтэй.

Анхаарах асуудал:

- Өөрийн үнэлгээний тайланд зөвхөн веб сайтын үнэлгээг оруулсан. Бусад сошиал сувгуудыг үнэлж оруулаагүй.

Зөвлөмж:

- Сургуулийн бусад олон нийтийн сувгуудаар хөтөлбөрийн нээлттэй ил, тод байдлын талаар мэдээлэл байнга оруулж үнэлж байх

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ:

Шалгуурт тавигдах шаардлагуудыг үзүүлэлт нэг бүрээр бүрэн хангаж байна гэсэн дүгнэлт гарсан 4-р шалгуур үзүүлэлтийг бүхэлд нь **БҮРЭН ХАНГАСАН** гэж үнэлэв.

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- *Элсэлтийн бодлого, дүрэм журам*
- Элсэгч, суралцагчийн сонгон шалгаруулалтыг дараах журмаар зохицуулдаг байна. Үүнд:
 - 2015.06.30 Захирлын №А/203 дугаар тушаалаар батлагдсан МУИС-ийн Сургалтын журам
 - Жил бүр оюутан элсүүлэх журам батлагддаг. Тухайлбал 2018 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн А/105 дугаар тушаалаар батлагдсан Бакалаврын өдрийн хөтөлбөрт оюутан элсүүлэх журам
 - 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/409 дугаар тушаалаар батлагдсан МУИС-д оюутан шилжүүлэн суралцуулах тухай журам

- **Элсэгчдийн ЕШ-ын дундаж оноо, хүсэлт гаргасан болон элссэн суралцагчдын харьцаа**

- Элсэхээр хүсэлт гаргасан болон элсэгчийн харьцаа сүүлийн 5 жилийн байдлаар дунджаар 12% байгаа элсэгчдийн ЭЕШ-ийн дундаж оноо өндөр байхад нөлөөлж байна. Мөн дундаж оноо 660 байгаа нь бусад салбар сургууль, хөтөлбөртэй харьцуулахад өндөр. /Өөрийн үнэлгээний тайлан /хуудас 69/, тэнхимийн жилийн тайлан/

Элссэн болон элсэхээр хүсэлт гаргасан хүний харьцааг авч үзвэл:

Он	2013	2014	2015	2016	2017
Элсэхээр хүсэлт гаргасан	4550	2636	4151	6614	7689
Элссэн	360	665	540	572	580
Элсэлтийн харьцаа	8%	25%	13%	9%	8%

- **Шинэ суралцагчдад зориулсан мэдээлэл, гарын авлага**

- 2015 оноос эхлэн жил бүрийн хичээлийн жилийн эхэнд Бакалаврын өдрийн хөтөлбөрт элсэгчдийн танилцуулах өдөрлөг гэж зохион байгуулдаг болсон байна. Энэ өдөрлөгийн үеэр сургалттай холбоотой мэдээлэл өгч гарын авлагаар хангадаг болжээ. Мөн ангийн зөвлөх багш нарыг томилон ажиллуулдаг байна.
- МИУС-ийн Бизнесийн сургууль нь Бизнесийн удирлага гэсэн нэгдсэн нэг хөтөлбөрөөр элсэлтээ авч суурь хичээлүүдээ орж гүйцээсний дараа 2- дугаар ангиас мэргэжил сонгох элсэлт, сургалтын журамтай болсоны дагуу 2015 оноос эхлэн сургалтын албанаас хөтөлбөр сонголтонд оролцох оюутнуудад “Бакалаврын тувшний оюутны мэргэжил сонгох журам”-ыг гаргаж жилд 2 удаа сурталчилгаа хийдэг болсон байна.
- Шинээр элсэж буй оюутнуудад зориулсан чиглүүлэх сургалтыг ийнхүү тогтмол явуулдаг болжээ. Энэ нь тэнхимийн тухайн хичээлийн жилийн төлөвлөгөөнд тухай бүр батлагдаад явдаг байна. /Тэнхимийн төлөвлөгөө/

- **Гадаад оюутны элсэлтийн тоо**

- 2014 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн А/214 дугаар тушаалаар батлагдсан МУИС-д гадаадын иргэнийг суралцуулах журамтай. Банк хөтөлбөрт элссэн гадаад оюутны дэлгэрэнгүй мэдээлэл одоогоор байхгүй.

Шалгуурыг хангасан байдал:

Суралцагч сонгох элсүүлэх гэсэн энэхүү шалгуур үзүүлэлтэнд тавигдах шаардлагуудыг **Бүрэн хангасан** гэж дүгнэв.

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагч сонгох, элсүүлэх үйл ажиллагаа нь холбогдох дүрэм, журмын хүрээнд явагддаг.
- Элсэхээр хүсэлт гаргасан болон элсэгчийн харьцаа сүүлийн 5 жилийн байдлаар дунджаар 12% байгаа элсэгчдийн ЭЕШ-ийн дундаж оноо өндөр байхад нөлөөлж байна. Мөн дундаж оноо 660 байгаа нь бусад салбар сургууль, хөтөлбөртэй харьцуулахад өндөр.
- Шинээр элссэн суралцагчдыг чиглүүлэх сургалт семинар тогтмол явуулдаг.

Анхаарах асуудал:

-

Зөвлөмж:

- Улсын үндэсний хэмжээний их сургууль гэдэг утгаараа Гадаад оюутны элсэлтийг нэмэгдүүлэх чиглэлд анхаарч ажиллах

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

-Зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө, тайлан

- МУИС нь оюутны хөгжилд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий **Оюутны хөгжил, үйлчилгээний** газартай бөгөөд мэргэжлийн тэнхимүүдтэй хамтран оюутны тэтгэлэг, оюутан солилцоо, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, соёл урлагийн арга хэмжээ зэргийг зохион байгуулж байна. www.num.edu.mn цахим хуудсанд зохион байгуулсан ажлын талаар мэдээлэл тогтмол ордог.
- Оюутанд зөвлөгөө өгөх хуваарийг санхүүгийн тэнхимийн багш нар гарган батлуулж хуваарийн дагуу зөвлөгөө мэдээлэл өгдөг. Оюутантай уулзсан чөлөөт уулзалтаар оюутнууд бүрэн хүлээн зөвшөөрсөн.

-Сэтгэл ханамжийн судалгаа, баримт материал

- Оюутнуудаас зөвлөн туслах үйлчилгээний талаар санал авч тэнхимийн хурлаар танилцуулдаг, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлж ирсэн талаар тэнхимийн хурлын тэмдэглэлээс үзэж танилцсан болно.

-Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тайлан мэдээ.

- “Оюутны албаны үйлчилгээ, өнөөгийн байдал, процессын шинжилгээ, сайжруулах боломж” сэдэвт судалгааны ажлыг 2016 онд зохион

байгуулсан бөгөөд зөвлөх үйлчилгээний үр дүнгийн талаар нэгдсэн судалгааны дүн гаргасан байна. Энэ нь 2016 онд хийгдсэн дээрх төслийн багийн түүвэр судалгааны үр дүнгээр нотлогдож байна.

-Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тайлан мэдээ

- Санхүүгийн тэнхимийн багш нар оюутны эрдэм шинжилгээ, судалгааны ажлын удирдан чиглүүлэгчээр ажилладаг бөгөөд сүүлийн 5 жилд Банк хөтөлбөрийн багш нарын удирдсан бакалаврын төгсөлтийн ажлын судалгааг хийсэн байна. Мөн Эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавьж хэлэлцүүлсэн оюутны тоо мэдээлэл өөрийн үнэлгээний тайлангийн 74 дүгээр хуудаст тодорхой бичигдсэн байна. Шинжээчдийн баг үүнийг нотлох баримтын хүрээнд үзэж баталгаажуулсан болно. Бүтээлийн жагсаалт тэнхимийн цахим хуудаст байршсан байна.

Банк хөтөлбөрөөр төгсөлтийн ажил удирдсан багш нарын төгсөлтийн ажлын судалгаа /2013-2018 он/

№	Багшийн нэр	2013-2014	2014-2015	2015-2016	2016-2017	2017-2018
1	А.Цэрэнтогоо	3	3	5		
2	Л.Оюун	6	1	5	7	5
3	Ө.Гэрэлт-Од	1	1	2	3	6
4	Г.Отгонсүрэн	1	5			
5	С.Ариунаа			2	2	5
6	Ё.Чимэдцогзол					1
7	Г.Гүнбилэг				1	2
		11	10	14	13	19

Тэнхим болон сургуулийн ЭШБХ-д оролцож буй хөтөлбөрийн оюутнуудад багш нар зөвлөгөө өгч, удирдаж оролцдог бөгөөд тэнхимээс шалгасан илтгэлүүд сургуулийн ЭШБХ-д ордог. Сүүлийн 5 хичээлийн жилд оюутны эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэлүүдээс 3 илтгэл тэргүүн байрт, 2 илтгэл 3 дугаар байрт, 1 илтгэл дэд байрт шалгарсан амжилт байна.

Шалгуурыг хангасан байдал:

Энэхүү шалгуур үзүүлэлтэнд тавигдах шаардлагыг Бүрэн хангасан гэж дүгнэв.

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутны хөгжил үйлчилгээний газартай байгаа http://student.num.edu.mn/page_id=127/ нь зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээг мэргэжлийн тэнхимүүдтэй хамтран хэрэгжүүлэх боломжтой болгосон.
- Оюутанд зөвлөгөө өгөх нэгдсэн хуваарийг батлуулж ажилладаг нь оюутнуудад бие даалт, диплом, ЭШХ-д зөвлөх үйлчилгээ авах боломжийг олгож байна.

Анхаарах асуудал:

- Зөвлөх багш нарын ачаалал тэнцвэргүй байгаад анхаарч ажиллах

Зөвлөмж:

- Эрдэм шинжилгээний ажлын тоон үзүүлэлтийг нэгтгэсэн байна. Гэвч чанарын болон үнэлгээ дүгнэлтийг гаргах шаардлагатай.

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

-Оюутны клубын зохион байгуулсан арга хэмжээ, тайлан мэдээ

- Санхүүгийн тэнхим нь дэргэдээ “Санхүүч”, “Банкир” гэсэн хоёр клубтэй бөгөөд оюутнууд дээрх клубуудад хамрагдаж олон нийтийн үйл ажиллагаанд оролцон өөрийгөө давхар хөгжүүлж байна. Жишээ татвал:
- Дээрх 2 клубын оюутнууд санал нэгдэж 2016 оны намрын ургац хураалтанд оролцсон, Хар толь илтгэлийн тэмцээн зохион байгуулсан, нийтийн эзэмшлийн зам талбай цэвэрлэсэн, үндэсний өв соёлоо дээдлэх өдөрлөг зохион байгуулсан гэх мэт олон ажлууд хийгддэг байна. Энэ талаар Өөрийн үнэлгээний тайлангийн 75 хуудаст дэлгэрэнгүй илтгэсэн байна.

-Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажлын үнэлгээ, урамшуулал

- Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлын талаарх ажил нь Бизнесийн сургуулийн тайлан хавтсаар нотлогдоно.
- Тэнхимээс оюутны олон нийтийн ара хэмжээнд оролцох оролцоог нэмэгдүүлэх зорилгоор жил бүр оюутны мэргэжил, спорт, урлагийн бага наадам зохион байгуулж тэргүүний баг хамт олон оюутныг урамшуулдаг байна.

-Цагийн ажил, үндсэн ажилд зуучилсан төгсөгч, оюутны тоон мэдээлэл.

- МУИС нь Суралцагчийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээний хүрээнд хамтын ажиллагаатай байгууллагуудтай хамтран олон талт үйл ажиллагааг явуулдаг. Тухайлбал:
 - Банк санхүүгийн академитай хамтран төгсөгчдөд ажлын байрыг таниулан сурталчилах зорилготой. Шинэ үеийн банкир төсөл /Төгсөгчидтэй хийх уулзалтаар/
 - Ажил олгогч байгууллагуудтай танилцах Job fair өдөрлөг
 - МУИС-ийн хөдөлмөр эрхлэлтийг харуулсан цахим хуудастай, мэдээлэл нь тогтмол шинэчлэгддэг.
<http://student.num.edu.mn/?cat=6/>

-Олимпиад, уралдаан тэмцээнд оролцсон суралцагчийн тоо, үр дүнгийн мэдээлэл

- Улсын чанартай хурал, олимпиадад оролцсон оюутан болон удирдсан багшийн мэдээлэл, амжилтын талаар сүүлийн 5 жилийн байдлаар тайланд тусгасан.
- Тухайлбал санхүүгийн менежментийн улсын олимпиадад жил бүр оролцож сүүлийн 3 жил дараалан 1-3 дугаар байрт шалгарсан байна.
- ХААН банкны нэрэмжит олимпиадад 2012 оноос хойш тасралтгүй оролцож 1 дүгээр байрыг 3 удаа, 2 дугаар байрыг 2 удаа эзэлсэн байна. харагдаж

-Урамшуулал, тэтгэлэг хөнгөлөлтөд хамрагдсан суралцагчдын тоо

- МУИС-д суралцагсдад тэтгэлэг олгох тухай нийтлэг журамтай. Одоогоор тус хөтөлбөрөөр суралцагч нь 16 төрлийн тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах боломж бүрдсэн байна.Жишээлбэл:
 - МУИС-ийн нэрэмжит тэтгэлэг
 - МУИС-ийн Эрдмийн зөвлөлийн нэрэмжит тэтгэлэг
 - Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг
 - Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг
 - Япон улсын Сумитомо корпорацийн нэрэмжит тэтгэлэг
 - Япон улсын Мицибуши корпорацийн нэрэмжит тэтгэлэг
 - Япон улсын Мицибуши UFJ сангийн нэрэмжит тэтгэлэг гэх мэт

Шалгуурыг хангасан байдал:

Шалгуур үзүүлэлтэнд тавигдах шаардлагыг **Бүрэн хангасан** гэж дүгнэв.

Онцлог зүйл/Туршлага:

- Мэргэжлийн чиглэлийн дагуу оюутны тогтмол үйл ажиллагаатай клубтэй бөгөөд мэргэжлийн тэнхимийн дэргэд байдаг нь оюутны олон нийтийн оролцоог дэмжиж байна.
- Оюутнуудын цагийн болон үндсэн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулдаг, нийт төгсөгчид төгсөөд 3 сарын дотор ажлын байртай болдог.

Анхаарах асуудал:

- Өөрийн үнэлгээний тайланд /хуудас79/ оюутнуудын оролцсон уралдаан тэмцээнүүдийг нэр зааж сүүлийн 5 жилээр гаргасан боловч чанарын үнэлгээ хийгээгүй.

Зөвлөмж:

- Оюутнууд сайн дурын ажил хийж байгаа ч сургалтын үнэлгээнд хөнгөлөлт эдэлдэггүйг анхаарч сургалтын үнэлгээнд оруулах, сайн дурын ажлыг идэвхжүүлэх

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

-Суралцагчийн шилжилт хөдөлгөөний судалгаа

- Сүүлийн 5 жилийн буюу тайлант хугацаанд нийт 17 оюутан шилжиж ирсэн байна. Үүний 30% нь Бизнесийн сургуулийн хөтөлбөр хооронд байна. Шилжиж явсан болон чөлөөлөгдсөн оюутны тоо тайлант хугацаанд 19 байна. Үүнээс шилжсэн оюутан 10 байна. оюутны гадагшилах урсгал бага харин шилжин ирэх урсгал илүү байдаг байна.

-Багц цагийн дүйцэл, шилжилт хөдөлгөөний судалгаа, дүрэм журам

- 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/409 дугаар тушаалаар батлагдсан МУИС-д оюутан шилжүүлэн суралцуулах тухай журмын дагуу жилд 2 удаа зохион байгуулдаг. Тус журамд дотоодын болон гадаадын сургуулиас шилжин суралцахад тавигдах шаардлагыг зааж өгсөн байна.
- Дээрх журмын 9-т багц цагийг дүйцүүлэх тухай заасан ба Мэргэжлийн хичээлийн багц цагийн дүйцэлийг мэргэжлийн тэнхим, Ерөнхий суурь хичээлийн дүйцэлийг Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын алба болон Бүртгэлийн алба хийж гүйцэтгэдэг байна.

Шалгуурыг хангасан байдал:

Энэхүү шалгуур үзүүлэлтэнд тавигдах шаардлагыг **Бүрэн хангасан** гэж дүгнэв.

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагчийн гадагшаа чиглэсэн урсгал шилжиж ирэх суралцагчаас давсан боловч бусад сургууль руу шилжилт багатай байгаа нь тус хөтөлбөрийн сургалт болон нэр хүнд сайн байгааг харуулж байна.

Анхаарах асуудал:

- Банкны хөтөлбөрөөс чөлөөлөгдсөн суралцагчийн шалтгааны 20 орчим хувь нь санхүүгийн гачигдлаас болсон байна. Энэ нь суралцагчийг боловсролын зээлийн сангийн мэдээллээр хангаагүй байх талтай гэсэн дүгнэлтийг өгч байна.

Зөвлөмж:

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

Төгсөлтийн баримт бичгийн загвар

- Төгсөлттэй холбоотой зохицуулалтыг 2015.06.30-ны өдрийн Захирлын №А/203 дугаар тушаалаар батлагдсан МУИС-ийн Сургалтын журмын 20 дугаар зүйлд зааж өгсөн.
- Жил бүр төгсөгчдөд тавих шаардлагыг хангасан суралцагчид Төгсөлтийн салбар комиссын хурлын шийдвэр гаргадаг. Нотлох баримтуудын хүрээнд үзэж баталгаажуулсан болно.

-Төгсөлтийн баримт бичгийг олгох дүрэм журмын хэрэгжилтийн байдал

- Тайлант хугацаанд Банк хөтөлбөрөөр 264 суралцагч төгссөн байна. Үүнээс 52 оюутан судалгааны ажил бичиж төгсжээ. Төгсөгчдөд тавигдах шаардлагыг бүрэн хангасан. /Тэнхмийн жилийн тайлан/

Шалгуурыг хангасан байдал:

Шалгуур үзүүлэлтэнд тавигдах шаардлагыг **Бүрэн хангасан** гэж дүгнэлээ.

Онцлог зүйл/Туршлага:

-

Анхаарах асуудал:

-

Зөвлөмж:

-

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ:

Шинжээчдийн баг 5 дугаар шалгуур үзүүлэлтэнд тавигдах шаардлагуудыг тус бүрд нь бүрэн хангасан гэж дүгнэсэн тул энэ шалгуурыг бүхэлд нь **БҮРЭН ХАНГАСАН** байна гэж үнэлэв.

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

-Хөтөлбөрийн хүний нөөцийн цогц бодлогын баримт бичиг, хэрэгжилтийн тайлан

- 2015.08.28-ны өдрийн Захирлын №А/234 дугаар тушаалаар батлагдсан МУИС-д зөвлөх, гэрээт ба зочин профессор, цагийн багш ажиллуулах журам

- Тайлант онд буюу сүүлийн 5 жилийн байдлаар 3 багш банк хөтөлбөрт ажилд орсон байна.
- Багш сонгон шалгаруулж авах босго өндөр байдаг тул шаардлага хангасан багш цөөн байдаг, үүнтэй холбогдож сүүлийн үед нэг багшид ногдох оюутны тоо өсөх магадлал өндөр байна гэсэн санал багш нартай хийсэн улзалтын явцад гарч байв.

-Доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жин, судалгаа /сүүлийн 5 жилээр/

- Санхүүгийн тэнхим нийтдээ 21 багштай бөгөөд нийт багш нарын 47.6% нь доктор зэрэгтэй багш байна. Дан банк хөтөлбөрийн багш нарын 42.8% нь докторын зэрэгтэй байна. Банк хөтөлбөрийн 2 багш докторын зэрэг горилж байна. /Өөрийн үнэлгээний тайлангийн 85, 86 хуудаст тайлагнасан байгаа ба газар дээр очиж танилцах үед багшийн хавтсаар баталгаажуулав/

-Багш, суралцагчдын тооны зохистой харьцааны судалгаа /сүүлийн 5 жилээр/

- Багшийн хүрэлцээний харьцуулсан хүснэгтээс харахад Санхүүгийн тэнхимийн 1 багшид дунджаар 15 оюутан ногдож байна. Харин банк хөтөлбөрийн 1 багшид ногдох оюутан дунджаар 10 байна.

-Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагад нийцсэн байдлын судалгаа.

- 2014.12.22-ны өдрийн Захирлын №А/414 дугаар тушаалаар батлагдсан МУИС-д профессор багш ажиллуулах журмын дагуу шаардлагад нийцсэн байна. /Багшийн хавтасаар баталгаажуулав./

-Багшийн цагийн ачаалал тооцсон судалгаа

Санхүүгийн тэнхимийн багшнарын сүүлийн жилүүдийн цагийн гүйцэтгэл

Хичээлийн жил	Ногдол цаг	Гүйцэтгэл /намар/	Гүйцэтгэл /хавар/	Илүү цаг
2013-2014	269,75	227,93	109,70	67,88
2014-2015	287,3	204,58	148,35	131,71
2015-2016	273,5	221,25	124,00	71,75
2016-2017	348,0	216,00	201,00	69,00
2017-2018	355,0	229,00	153,00	59,00

Тайлант хугацаанд санхүүгийн тэнхимийн багш нарын ачааллыг гаргасан хүснэгт өөрийн үнэлгээний тайланд байгаа ногдолоос харвал гүйцэтгэл нь дунджаар 1.2 дахин өндөр байна.

Багшлах хүнд тавигдах шалгуур өндөр, цагийн ачаалал их, цалин хөлс бага гэсэн шалтгаанаар багш хийх хүн харьцангуй цөөн байдаг гэсэн тайлбарыг өгч байна.

-Багш нарт олгосон урамшууллын судалгаа

- Багш нарт урамшуулал олгохдоо түр журам батлуулан мөрдүүлдэг. Тухайлбал 2018.12.28-ны өдрийн А/473 дугаар тушаалаар батлагдсан МУИС-ийн багш, ажилтанд урамшуулалт цалин олгох түр журмаар зохицуулагдаж байна.
- Багш нарт илүү цагийн хөлсийг дээрхи журмын дагуу бодож олгодог.
- Мөн багш нарын ажлыг 2015 ба 2018 онуудад дүгнэж дэд профессор, профессорын зэрэглэд дэвшүүлэн ажиллуулах журамын дагуу 2 багш профессорын, 3 багш дэд профессорын зэрэглэлд дэвшин ажиллаж байна. Багш нарыг ийнхүү зэрэглэл ахиулсан ажиллуулснаар тэдний цалин урамшууллын хэмжээ нэмэгддэг байна.

Шалгуурыг хангасан байдал:

Шалгуурт тавигдах шаардлагыг **Бүрэн хангасан** гэж дүгнэв.

Онцлог зүйл/Туршлага:

- Хүний нөөцийн бодлого болон багш ажиллуулах журмын дагуу сонгон шалгаруулалтыг явуулж байна.
- Нийт банк хөтөлбөрийн багшид эрдмийн зэрэг цолтой багш нарын эзлэх хувь 42.8% байгаа дундаж үзүүлэлтээр өндөр байна.
- Багшийн цагийн ачааллыг тооцож илүү цаг боддог.

Анхаарах асуудал:

- Багш нарын цагийн ачааллын мэдээнээс харахад илүү цаг дунджаар 70 цаг байна. Энэ нь эргээд сургалтын чанарт сөргөөр нөлөөлөх, багш нарын судалгаа хийх цагийг бууруулах магадлалтай байна.

Зөвлөмж:

- Профессор багш нарын ажлын гүйцэтгэл, үр дүнгээс хамаарсан урамшууллыг нэмэгдүүлэх боломжийг эрэлхийлэх

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

-Багшлахуйн ур чадвар, судалгааны ур чадвар, суралцах хэрэгцээг тодорхойлсон судалгаа, судалгааны дагуу хийсэн ажлын баримт

- Тус сургуульд нийтлэг хэрэглэгддэг 42 журмаас 15 журам нь хүний нөөцийн бодлоготой холбоотой журмууд байна.
- МУИС-ийн захирлын 2018.11.27-ны өдрийн А/439 дугаар тушаалаар батлагдсан “МУИС-ийн судалгааны ажлын санхүүжилтийн журам”-ийн дагуу жил бүр санхүүжүүлэх суурь судалгааны төслийн саналыг авч санхүүжүүлдэг.

-Төлөвлөгөө, тайлан

- Тэнхимийн багш нарыг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлдэг бөгөөд Өөрийн үнэлгээний тайланд /хуудас 89, 92 /дэлгэрэнгүй тайлагнасан.

-Багшийг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлж чадавхжуулсан судалгаа.

- 2016 онд Багшийн хөгжлийн төвийг байгуулан багш нараа тодорхой сургалт, хөтөлбөрүүдэд хамруулж байна.

Шалгуурыг хангасан байдал:

Шалгуурт тавигдах шаардлагыг **Бүрэн хангасан** гэж дүгнэв.

Онцлог зүйл/Туршлага:

- Багшийн хөгжлийг дэмжих чиглэлээр МУИС-ийн судалгааны ажлын санхүүжилтийн журамтай.
- Сүүлийн жилүүдэд багш нарын цалинг тогтмол 10 гаруй хувиар жил бүр нэмэгдүүлсэн.

Анхаарах асуудал:

- Багш нарын бусад мэргэжлийн судалгааны тайлангаас мэргэжил дээшлүүлсэн талаарх үзүүлэлт байгаа боловч банкны төрөлжсөн сургалт дүүргэсэн хувь бага.

Зөвлөмж:

- Гадаад дотоодод төсөл, хөтөлбөр, сургалт семинарт хамрагдсан багш нарын сургалт, судалгаа, шинжилгээний ажилд ямар үр дүн, ахиц дэвшил бий болж байгааг дүгнэх

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- *Боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инноваци, ашигтай загвар, патентын тоон судалгаа*
 - Эрдэм шинжилгээний бүтээлээс жил бүр олон улсын нэр хүнд бүхий сэтгүүлд эшлэл авагдаж байна. Энэ нь өөрийн үнэлгээний тайлан /хуудас 91/ дээр сэтгүүл, багшийн нэртэйгээр бичигдсэн бөгөөд газар дээрх шалгалтаар бүтээлийн жагсаалттай тулгаж баталгаажуулав.
- *Бодлогын баримт бичиг, дүрэм журам*
 - МУИС-ийн захирлын 2018.11.27-ны өдрийн А/439 дугаар тушаалаар батлагдсан “МУИС-ийн судалгааны ажлын санхүүжилтийн журам”-ийн дагуу багш нарт зэрэглэлийг харгалзан санхүүжилт олгож байна.

- *Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, судалгааны ажлын тайлан мэдээ, хөтөлбөрт тусгагдсан байдал*
 - Тайлант хугацаанд Санхүүгийн тэнхимийн багш нар нийт 11 төсөл гүйцэтгэсэн. Олон улсын мэргэжлийн сэтгүүлүүдэд 58 өгүүлэл, нэг сэдэвт бүтээлийг хэвлүүлсэн байна. Үүнээс банк хөтөлбөрийн багш нар 7 төсөл дээр ажиллажээ. Мөн 40 орчим төсөл, хөтөлбөрт зөвлөх, удирдагчаар ажилласан.
- *Нийтлэгдсэн бүтээл, судалгааны ажил, эшлэгдсэн тоо*
 - Өөрийн үнэлгээний тайланд /хуудас 90/ тэнхимийн багш нарын бүтээлийн судалгааны тоймыг сүүлийн 5 жилээр гаргасан бөгөөд энэ нь багш нарын бүтээлийн жагсаалтаар баталгаажсан. Сүүлийн 5 жилийн байдлаарх бүтээлийн тоо:
 - ✓ Үндэсний эрдэм шинжилгээний өгүүлэл 81
 - ✓ ОУ-ын сэтгүүлд хэвлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэл 49
 - ✓ Үндэсний эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэл 45
 - ✓ ОУ-ын хуралд тавьсан илтгэл 72
 - ✓ Сурах бичиг, гарын авлага /бичсэн, хамтарсан, хянасан/ 791 хх
 - ✓ Нэг сэдэвт бүтээл 27.3 хх
 - ✓ Хэрэгжүүлсэн төсөл, суурь судалгааны ажил 43
 - Эшлэгдсэн бүтээлийн тоо сүүлийн 5 жилийн байдлаар 61 байна. /Бизнесийн сургуулийн тайлангаар нотлогдсон/
- *Зарцуулсан төсөв, тайлан*
 - Өөрийн үнэлгээний тайланд /хуудас 55/ Бизнесийн сургуулийн 2013-2017 оны зардлын задаргааг хураангуйлан оруулсан бөгөөд санхүүгийн тайлангаар нотлогдсон. Нийт зардлын дунджаар 4%-ийг эрдэм шинжилгээний ажилд зарцуулж байна. 2017 онд 160.9 сая төгрөг зарцуулсан байна.

Шалгуурыг хангасан байдал:

Шалгуурт тавигдах шаардлагуудыг **Бүрэн хангасан** байна гэж дүгнэв.

Онцлог зүйл/Туршлага:

- Багш нарын эрдэм шинжилгээний бүтээлийн талаар жил бүр судалгаа хийж байна.
- Эрдэм шинжилгээний бүтээлээс жил бүр олон улсын нэр хүнд бүхий сэтгүүлд эшлэл авагдаж байна.
- Хагас жил бүр тогтмол гаргадаг “Мөнгө, санхүү” сэтгүүлтэй байгаа нь багш нарт судалгааны ажлаа нийтийн хүртээл болгох боломжийг нээж өгч байна.

Анхаарах асуудал:

- Боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инноваци, патентын тоог нэмэгдүүлэх тал дээр анхаарч ажиллах

Зөвлөмж:

-

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

-Багшийн өөрийн үнэлгээний тайланг үнэлэх дүгнэх журам, хэрэгжилтийн тайлан

Хөтөлбөр хэрэгжүүлэгч санхүүгийн тэнхимийн багш нар нь дараах баримт бичгүүдийн хүрээнд өөрийн үнэлгээний тайлангаа бичиж тэнхимийн хурлаар хэлэлцүүлэн жилийн ажлаа дүгнүүлдэг байна. Үүнд:

- 2012.12.07-ны өдрийн Захирлын №652 дугаар тушаалаар батлагдсан МУИС-ийн багшийн ажлын нэгдсэн үнэлгээний журамтай бөгөөд жил бүр аттестатчилалд орох багш нарын нэрийг захирлын тушаалаар баталдаг.
- 2015.08.28 -ны өдрийн Захирлын №234 дугаар тушаалаар батлагдсан МУИС-ийн хүндэт цол олгох журам
- 2015.08.28-ны өдрийн Захирлын №А/234 дугаар тушаалаар батлагдсан МУИС-д зөвлөх, гэрээт ба зочин профессор, цагийн багш ажиллуулах журам

-Багшийн өөрийн үнэлгээний тайлан

- МУИС-ийн захирлын 2003 оны 425 дугаар тушаалаар анх баталж, 2003, 2005, 2011 онуудад нэмэлт өөрчлөлт оруулсан МУИС-ийн багшийн орон тоо, ажлын үнэлгээний журам"-аар албан тушаалын зэрэглэлээс хамааран багш нарын гүйцэтгэх сургалт, эрдэм шинжилгээ болон бусад ажлын багц цаг, ажлын ачааллыг тодорхойлж байна. Тус журмаар 15 хүртэл жил ажилласан багшийг 3 жилд, 15-аас дээш жил ажилласан бол 5 жилд 1 удаа үнэлдэг.
- Багш нарыг заах арга зүй, мэргэжлийн ур чадвар, мэдээллийн технологийн ашиглалт, эрдэм шинжилгээний ажлын үр дүн зэрэг үзүүлэлтүүдээр сургуулиас аттестатчилдаг. 2016 оны хичээлийн жилд багш нарыг аттестатчилсан тус тэнхимийн 10 багш хамрагдаж дунджаар 77,5% үнэлгээ үзүүлсэн байна.

-Хөндлөнгийн үнэлгээний дүн

- SiSi системээр улирал бүр 14 үзүүлэлт бүхий асуулгаар багшийн заах арга зүй, мэдлэг чадварын талаар тогтмол хөндлөнгийн үнэлгээг хийдэг.

-Багшийн үнэлгээний дагуу авч хэрэгжүүлсэн ажил арга хэмжээний тайлан мэдээ

- Тайланд жилүүдэд хийгдсэн багш нарын үнэлгээний дундаж дүн дараах байдалтай байна. Үүнд:
 - Профессор багш 88 оноо

- Дэд профессор багш 80 оноо
- Ахлах багш, багш нар 77 оноо байна.

- Багшийн хавтас

- Багш тус бүрээр багш ажиллуулах журмын дагуу материал бүрдүүлэн хавтасласан байна. Сургууль дээр ажиллах үед багшийн хавтаснуудыг багш бүрээр тулгаж баталгаажуулав.

Шалгуурыг хангасан байдал:

Шалгуур үзүүлэлтийг **Бүрэн хангасан** гэж дүгнэв.

Онцлог зүйл/Туршлага:

- Багшийн ажлыг үнэлэх нэгдсэн аргачлал бүхий журамтай байгаа нь багш бүр өөрийн үнэлгээг урьдчилан тооцоолох боломжтой байна.

Анхаарах асуудал:

-

Зөвлөмж:

-

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ:

Энэхүү шалгуур үзүүлэлтэнд тавигдах шаардлагуудыг нэг бүрчлэн бүрэн хангасан байгаа тул 6-дугаар шалгуурыг бүхэлд нь **БҮРЭН ХАНГАСАН** байна гэж үнэлэв.

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

-Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын удирдлага, зохион байгуулалтын схем

МУИС-ийн хэмжээнд дотоод чанарын баталгаажуулалтыг хариуцсан үндсэн чиг үүрэг бүхий бүтцийн нэгжийг МУИС-ийн захирлын 2017 оны Б/500 тоот тушаалаар байгуулагдсан байна. Энэ нэгж нь Сургалтын нэгдсэн газрын Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын алба юм. Тус алба нь 10 хүний бүрэлдэхүүнтэй хөтөлбөрийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийх, дутагдал доголдлыг засаж залруулах үүргийг хүлээдэг байна.

Бүрэлдэхүүн сургуулиудад Хөтөлбөрийн үйл ажиллагаанд шууд хяналт тавих үүрэг бүхий тусгай орон тооны нэгж байхгүй. Мэргэжлийн хөтөлбөрийн хороод өөрсдийн үйл ажиллагаандаа хяналт тавьж сайжруулалтыг хийх үүрэгтэй байдаг.

“Банк” хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайландаа /тайлангийн 97 дугаар хуудас/ хөтөлбөрийн чанарыг үнэлж, тогтмол сайжруулалт хийх үүрэг бүхий орон тоог хөтөлбөрт бий болгох, эсвэл тодорхой нэг багшид хариуцуулан өгч түүний “В” цагийн гүйцэтгэлд нэмж тооцох боломжийг бий болгох саналыг дэвшүүлсэн байна.

-Чанарын дотоод баталгаажуулалтын тогтсон бодлого, журам, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, үнэлгээ

МУИС-иас сургуулийн үйл ажиллагааны ахиц дэвшлийг хэмжих гүйцэтгэлийн үнэлгээний 15 түлхүүр үзүүлэлт (KPI)-ийг тодорхойлсон нь МУИС-ийн хэмжээнд дотоод чанарыг баталгаажуулах суурь бодлого болжээ. Энэ түлхүүр үзүүлэлтийн онцлог нь “МУИС-ийг 2016-2024 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөө”-г боловсруулахдаа МУИС-ийн алба, нэгж, бүрэлдэхүүн сургууль, тэнхимийн түвшинд 2024 он гэхэд ямар хэмжээнд хүрсэн байхыг гаргасан байна. Харин энэ түвшинд хүрэхийн тулд завсарын хугацаанд гүйцэтгэх зорилтуудыг үзүүлэлт бүрээр гаргаж гүйцэтгэлийг үнэлж дүгнэж байхаар зохицуулжээ. Үүнийг гол хариуцаж буй орон тооны нэгж алба нь МУИС-ийн Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын хэлтэс юм. Энэ хэлтэс 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн хөтөлбөрийн чанарын баталгаажуулалттай холбоотой ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна. Ажлын төлөвлөгөөнд 14 үндсэн ажил төлөвлөгдсөн байна. Ажлын төлөвлөгөөг “Банк” хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлангийн 98 дугаар хуудаснаас үзэж болно. Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалтын хүрээнд төлөвлөгдсөн ажлуудыг дараах шат шатны төлөвлөгөөнүүдээс харж болохоор байна. Үүнд:

- МУИС-ийн стратегийн төлөвлөгөө 2016-2024 (хэвлэмэл хавтас)
- МУИС-ийн БС-ийн стратегийн төлөвлөгөө 2016-2024 (хэвлэмэл хавтас)
- БС-ийн Санхүүгийн тэнхимийн ажлын төлөвлөгөө (2014-2017)
- БС-ийн Санхүүгийн тэнхимийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөө

- Чанарын дотоод баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангах чиглэлээр хийсэн ажлын тайлан мэдээ

Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалтанд хөтөлбөрт оролцог талуудын оролцоог хангаж ажиллах чиглэлээр дараах ажлууд хийгддэг байна. Үүнд:

- *Багш нарын оролцоог хангах чиглэлээр:* Хөтөлбөрийг гардан хэрэгжүүлэгч нь багш нар байдаг тул багш нар энд голлох чиг үүрэгтэй оролцдог байна. Багш нар хөтөлбөрт орсон сургалтын төлөвлөгөө, бүтэц, олгох мэдлэг, эзэмшүүлэх чадварын талаар судалгаа хийж саналаа хөтөлбөрийн хорооны хуралд байнга илтгэж байх үүрэгтэй байдаг.
- *Оюутнуудын оролцоог хангах талаар:* Оюутнуудаар суралцаж буй хөтөлбөрийн чанарыг үнэлүүлэх, тэдний санал бодолыг авах гол механизм нь МУИС-ийн SiSi цахим мэдээлийн систем байдаг. Оюутнуудаас авсан

сэтгэл ханамжийн судалгааг үндэслэн сургалтын бодлого төлөвлөлтөнд өөрчлөлт оруулах, сайжруулалт хийх, оюутныг бодитойгоор үнэлэх төгсөх ангийн оюутнуудыг хөндлөгийн шалгалтанд хамруулах зэрэг ажлууд хийгддэг байна. Тухайлбал олон улсын магадлан итгэмжлэлийн хүрээнд “Peregrine academic service” байгууллагатай гэрээ хийж оюутны мэдсэн байвал зохих мэдлэг эзэмшүүлсэн ур чадварыг үнэлүүлж байна.

- *Дээд болон дунд шатны удирдах ажилтнуудын оролцоог хангах чиглэлээр:* Бизнесийн сургууль нь 2013-2014 оны хичээлийн жилээс эхлэн дотоод бүтэц зохион багуулалтаа Хөтөлбөрийн хэлбэрт шилжүүлэн ажиллаж үзсэн бол 2014-2015 оны хичээлийн жилээс дахин өөрчилж барууны орнуудын жишгээр анх удаа тэнхимгүй бүтцээр ажиллаж, оюутан судлах хичээл болон багшаа өөрөө чөлөөтэй сонгох боломжийг олгох зорилготой ажиллуулсан байна. Энэ зохион байгуулалтын үр дүнд тодорхой ахиц өөрчлөлтүүд сургалтанд гарсан гэж үздэг байна. Жишээлбэл: удирдлагын шат дамжлаг цөөрөх багшийн өөртөө тавих шаардлага өндөрсөх, багш нарын дунд харилцааны эерэг орчин бүрдэх зэрэг давуу талууд байсан гэж дүгнэж байна.
- *Төгсөгчдийн оролцоог хангах чиглэлээр:* Хөтөлбөрийн чанарыг сайжруулах зорилгоор төгсөгчдөөс асуулгын аргаар судалгаа авч гарсан үр дүнг нэгтгэн шинжилгээ хийж зарим өөрчлөлтийг оруулдаг. Мөн үүнээс гадна “Төгсөгчийг мөшгих”, “Ажил олгогчийн сэтгэл ханамж” зэрэг судалгааг явуулахаар төлөвлөж байна. Санхүүгийн тэнхмийн 60 жилийн ойн хүрээнд Монгол банк болон арилжааны 14 банкинд ажиллаж байгаа төгсөгчдийн уулзалтыг зохион байгуулж саналыг авч сургалтын хөтөлбөрт тусгах ажиллагааг явуулсан байна.
- *Ажил олгогчдын оролцоог хангах чиглэлээр:* Оюутнуудын үйлдвэрлэлийн дадлагыг мэргэжлийн хүрээнд чанартай хийлгэх, мөн банкны байгууллагуудын санал хүсэлтийг авах зорилгоор банкуудтай гурвалсан гэрээ байгуулж ажилладаг байна. Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын хүрээнд оролцогч талууд болох төгсөгчид, ажил олгогчдын дунд сургалттай холбоотой санал асуулга явуулсан болох нь өөрийн үнэлгээний тайлан болон холбогдох баримт бичгийн хавтсанд байгаа материалаар баталгаажиж байна.

Шалгуурыг хангасан байдал:

Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт сайжруулалт гэсэн шалгуур үзүүлэлтийг тавигдах шаардлагуудын түвшинд **Бүрэн хангасан** гэж дүгнэв.

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтыг МУИС-ийн түвшинд хянах тусгай хэлтэстэй болсон.
- МУИС-ийн захирлын 2019.02.26 өдрийн А/77 тоот тушаалаар хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх зорилго бүхий ажлын хэсгийн гишүүд болон ажлын хэсгийн удирдамжийг баталсан.

- 2016-2018 оны үйл ажиллагааг хамруулан төлөвлөгөөний гүйцэтгэлийг хэмжих KPI –ийг тодорхойлсон.
- 2018.12.10-ны өдөр Үр дүнгийн гэрээний тайлан бичих, хэлэлцүүлэх удирдамжтай болсон.

Анхаарах асуудал:

-

Зөвлөмж:

-

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

Илрэл нотолгоо:

-Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, дүгнэлт, үр дүн

МУИС-ийн Бизнесийн сургууль, ХНХЯ-ны дэргэдэх Нийгмийн хамгааллын судалгааны институттэй хамтран сүүлийн 5 жилд тус хөтөлбөрөөр төгсөгчдийн судалгааг явуулахад жил бүр 30 оюутан элсүүлж 24 мэргэжилтэн төгсгөж байгаа бөгөөд тэдний ажил эрхлэлтийн түвшин 97,0 хувьтай гарсан байна. Монгол Улсын хэмжээнд их дээд сургууль төгсөгчдийн 68,4 хувь нь ажлын байраар хангагддаг гэсэн судалгааг ХНХЯ-аас хийсэн судалгаагаар гаргасан байдаг бол МУИС-ийн Банк хөтөлбөрөөр суралцаж, төгсөгчдийн ажлын байрны хангамж улсын дундажаас $28,6\% = /97,0 - 68,4/$ буюу 30 шахам хувь дээгүүр түвшинд байна.

МУИС-ийн Бизнесийн сургуулийн өөрсдийн хийсэн судалгаагаар тус хөтөлбөрөөр төгсөгчдийн 72 хувь нь төгссөн эхний 6 сарын дотор багтаж ажлын байртай болдог гэсэн тоо мэдээлэл ч бас гарсан байна.

-Төгсөгчдийн карьер өсөлтийн судалгаа, дүгнэлт, үр дүн

МУИС нь 1962 оноос эхлэн банкны мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн бөгөөд одоо 53 дахь төгсөлтөө хийж байна. Санхүүгийн тэнхимээс энэ хичээлийн жилээс эхлэн төгсөгчдийн карьер өсөлтийн судалгааг авч эхэлжээ. Судалгаагаар банкны салбарт удирдах болон дунд тушаалын алжын байранд ажиллаж байгаа хүмүүсийн дийлэнх олонх нь тус сургуулийг төгсөн гарсан мэргэжилтнүүд байдаг гэсэн ерөнхий мэдээлэлтэй байгаа бөгөөд нарийвчилсан судалгааг ирэх жилүүдэд гүйцээж гаргах зорилготой ажиллаж байгаа юм байна. Энэ судалгааг Монголын банк-санхүүгийн академитай хамтран гаргаж байгаа юм байна.

-Төгсөгчдийн ажлын байраар хангагдах хүртэлх хүлээх хугацааны судалгаа, дүн шинжилгээ

МУИС-ийн Бизнесийн сургуулийг “Банк” хөтөлбөрөөр төгсөгчидтэй хийсэн уулзалтаар “Та төгссөнөөс хойш ямар хугацаанд ажлын байраар хангагдсан бэ? гэсэн асуулт оруулахад тухайн онд төгссөн 24 хүний 9 нь нэг сарын дотор гэсэн бол 15 хүн 4-6 сарын дотор, 9 хүн суралцаж байх хугацаандаа ажлын байраа олсон гэсэн хариултыг өгчээ. Эндээс харвал тус хөтөлбөрөөр төгсөгчид ажлын байрны хүндрэл гардаггүй байна. Гэхдээ ажлын байрны хангамжийг үндэслэн хэт их элсэлт авах нь цаанаа ажлын байрны эрэлт их байна гэсэн үг биш гэдгийг анхаарч ажиллах ёстой. Ийм ч учраас элсэлтэнд илүү их ач холбогдол өгдөггүй болох нь ажиглагдсан болно.

-Оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа, дүн шинжилгээ /Ажил олгогч, мэргэжлийн холбоод, төгсөгч гэх мэт/

МУИС-ийн Бизнесийн сургуулиас төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаа хийх багийг 2017 оны 03 сараас 06 сарын хооронд гарган ажиллуусан байна. Судалгааг хувийн мэдээлэл, ажил эрхлэлт, бакалаврын сургалтын талаар гэсэн 3 үндсэн хэсэгтэй авчээ. Судалгаанд 2012-2016 оны хооронд төгссөн 33 төгсөгч хамрагдсан байна. Тэдний 87% нь сэтгэл ханамж өндөр гэж хариулсан байна.

Мөн төгсөгчдийн дунд явуулсан судалгаагаар МУИС-ийг “Банк” хөтөлбөрөөр төгсөгчид төгссөн эхний 6 сарын дотор ажлын байраар бүрэн хангагддаг, нийт төгсөгчдийн 87 хувь нь сэтгэл хангалуун гэж хариулсан зэргээс үзвэл хөтөлбөрт оролцогч талуудын сэтгэл ханамж өндөр байна гэж үзэх үндэслэлтэй байна.

Шалгуурыг хангасан байдал:

Хөтөлбөрийн үр дүн гэсэн энэхүү шалгуур үзүүлэлтэнд тавигдах шаардлагуудыг нэг бүрчлэн хагаж байгаа тул **Бүрэн хангасан** гэж дүгнэв.

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөгчдийн сэтгэл ханамж маш өндөр
- Сургуулиа төгсөөд 6 сарын дотор 72 хувь ажилтай болсон байдаг.
- Банк санхүүгийн академи төрийн бус байгууллаатай хамтын ажиллагаатай байдаг

Анхаарах асуудал:

-

Зөвлөмж:

- Ажил олгогч, төгсөгчдөөс авсан судалгааны үр дүн юу гэж гарсан, түүний дагуу ямар шинэчлэлт өөрчлөлтийг хийгээд ямар үр дүнд хүрсэн талаар тайлагнадаг систем бүрдүүлэх.

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

-Магадлан итгэмжлэх байгууллагаас гаргасан дүгнэлт, зөвлөмж, шаардлага, магадлан итгэмжилсэн шийдвэр

МУИС-ийн Бизнесийн сургуулийн 11 хөтөлбөр олон улсын хөндлөнгийн магадлан итгэмжлэлийн ACBSP байгууллагаар магадлан итгэмжлүүлж, гэрчилгээ авсаны нэг нь “Банк” хөтөлбөр юм. Тус хөтөлбөрөөр суралцагсад жил бүр орц гарцын түвшингөө хөндлөнгийн байгууллагаар шалгуулж, ахиц дэвшлийн тайлан бичиж хөтөлбөрийн үр дүнгээ үнэлүүлж байна.

Харин үндэсний магадлан итгэмжлэлийн байгууллагаар тус хөтөлбөр нь 2011 онд орж амжилттай үнэлүүлж 5 жилийн эрх авч эрхийн хугацаа 2016 онд дуусч 2 дахь удаагаа магадлан итгэмжлүүлэхээр өөрийн үнэлгээний тайлангаа бичиж ирүүлсэн байна.

Мэргэжлийн түвшинд хүлээн зөвшөөрөгдөх байдлын тухайд авч үзвэл: Банк санхүүгийн академи төрийн бус байгууллагаас санаачлан зохион байгуулсан банкны системд ажиллагсдын “Мэдлэг, ур чадварын суурь шаардлага, сургалтын хөтөлбөр батлах тухай” нэгдсэн стандартыг батлуулсан. Энэ стандарт нь банк хөтөлбөрөөр суралцагсад тавигдах суурь шаардлага, үндэсний хэмжээнд мөрдөгдөх бодлогын баримт бичиг гэж үзэж байна.

Санхүүгийн тэнхим 2016-2017 оны хичээлийн жилээс эхлэн тус академитай хамтран харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж, хамтын ажиллагааны төлөвлөгөө гарган ажиллаж байгаа юм байна. Мөн 2017-2018 оны хичээлийн жилээс эхлэн сургалтын хөтөлбөртөө Банк санхүүгийн академиар мэргэжлийн түвшинд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлаа эхлүүлжээ.

- Олон улсын магадлан итгэмжлэлийн үр дүн (2013)
- Үндэсний магадлан итгэмжлэл (2011)
- Үндэсний ажил мэргэжлийн үнэлгээ /2017-2018 оны хичээлийн жил/

-Хөтөлбөрөөр төгсөгчдийг мэргэжлийн салбарт хүлээн зөвшөөрсөнийг нотлох баримт бичгийн судалгаа, /мэргэжлийн зэрэг, эрхийн үнэмлэх гэх мэт/

- Олон улсын хөндлөнгийн магадлан итгэмжлэлийн ACBSP байгууллагаар магадлан итгэмжлүүлж, гэрчилгээ авсан
- Үндэсний магадлан итгэмжлэлээр 2011 онд орж хүлээн зөвшөөрөгдсөн
- Монголын Банк санхүүгийн академи төрийн бус байгууллагатай мэргэжлийн түвшинд хамтран ажиллах санамж бичиг байгуулсан
- МУИС-д хийгдсэн шинэчлэлийн хүрээнд бүх хөтөлбөрүүдэд өөрчлөлт орсон
- Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалтын хэлтэс ажилладаг
- Ажил олгогчид сэтгэл ханамж өндөр
- Төгсөгчид 6 сарын дотор ажлын байраар бүрэн хангагддаг

- Банк хөтөлбөрөөр төгсөгчдийг банк санхүүгийн академи төрийн бус байгууллагаар мэргэжлийн түвшинд үнэлүүлэх ажлыг эхлүүсэн зэрэг нотолгоо болох олон баримт бичиг, ажлуудыг дурьдаж болохоор байна.

-Дотоод, гадаадын дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн хувь

МУИС-ийн Бизнесийн сургуулийг сүүлийн 5 жилд “Банк” хөтөлбөрөөр суралцаж төгссөн хүмүүмийн хувьд авч үзвэл:

- 2011-2012 оны хичээлийн жилд төгссөн төгсөгчдөөс 5 хүн БНХАУ, Тайваньд
- 2014-2018 оны хооронд төгсөгчдөөс 13 хүн АНУ, Япон, БНХАУ, болон өөрийн эх орондоо ахисан түвшний сургалтанд хамрагдан суралцаж байна.

Шалгуурыг хангасан байдал:

Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх гэсэн энэхүү шалгуур үзүүлэлтэнд тавигдах шаардлагуудыг тус бүрт нь **Бүрэн хангасан** гэж дүгнэв.

Онцлог зүйл/Туршлага:

- Дотоодод болон Олон улсад магадлан итгэмжлэгдсэн.
- Мэргэжлийн холбоодтой хамтран ажиллах эхлэлийг тавьсан.

Анхаарах асуудал:

-

Зөвлөмж:

- Элсэлт их гэдэг нь эрэлт их гэсэн утга биш юм. Даяршиж байна, хиймэл оюун ухааны үр дүнд зарим мэргэжил устах магадлал байна.
- Сургалтаас судалгаанд шилжих зорилтын хүрээнд Эрдэм шинжилгээ судалгааны ажилд оюутнуудыг өргөнөөр татан оролцуулах,
- Сургалтын өнөөгийн арга технологид эрс өөрчлөлт оруулаж, үлгэрлэн ажиллах

ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ

- Бизнесийн удирдлага нэгдсэн хөтөлбөрөөр бус тодорхой мэргэжлийн хөтөлбөрөөр нэр заан оюутныг элсүүлэх
- Банк хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд байгаа ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэжлийн хичээлүүдийн нэгдсэн уялдааг харуулсан матриц боловсруулах. Өөрөөр хэлбэл: Мэргэжилтний эзэмшвэл зохих 35 ур чадварыг хоорондоо уялдаа бүхий нэг хавтгайд буулгасан зураглал /матриц/ гаргах
- Хөтөлбөрт хийгдсэн шинэчлэл нь зөвхөн тухайн оны элсэгч биш, өмнөх жилүүдэд хуучин хөтөлбөрөөр элссэн элсэгчдийн сургалтын төлөвлөгөөг SiSi

системд өөрчилдөг нь онцлог байлаа. Өөрөөр хэлбэл, оюутан төгсөх үед өөрийн анх элссэн сургалтын төлөвлөгөөгөөр бус, шинэчлэн батлагдсан сургалтын төлөвлөгөөгөөр төгсөх шаардлагатай болдог. Энэ нь оюутны хувьд 3-6 орчим багц цагийн зөрүү үүсэх, нэмж судлах шаардлага үүсгэдэг. Үүнийг оюутны эрх ашигт нийцүүлэн шийдвэрлэх

- Лицензгүй програмууд сургалтад ашиглаж буй нь эрсдэлтэйг бодолцох
- Банк хөтөлбөрийн хүрээнд мэргэжлийн ном, сурах бичгийн олдоц бага, 2010 оноос хойшхи, сүүлийн үеийн сурах бичиг ховор байгаа гэсэн оюутны шүүмжийг анхаарах.

ДҮГНЭЛТ

№	Шалгуур	Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаа гүй (0)	Тайлбар
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	3(6)	--	--	
2	Сургалтын үйл ажиллагаа	3(6)	--	--	
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	3(6)	--	--	
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	5(10)	--	--	
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	5(10)	--	--	
6	Багшийн үйл ажиллагаа	4(8)	--	--	
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	3(6)	--	--	
	Дүгнэлт	Хөтөлбөрийг шинжээчдийн багаас БҮРЭН ХАНГАСАН гэж үнэлэв.			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг МУИС-ийн Бизнесийн сургуулийн “Банк” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Бизнес, удирдлагын чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагч Д.ДАЛХЖАВ
 Шинжээчийн багийн гишүүнЗ.ОЮУНЦАЦАРАЛ
 Шинжээчийн багийн гишүүн Т.УЯНГА

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

№	Нэр	Албан тушаал	Зэрэг цол	Ажилласа н жил	Заадаг хичээл

II. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал
			Орон нутгийн, гадаад, Дотуур байранд амьдардаг гэх мэт

III. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэрс	Байгууллага	Албан тушаал

IV. Төгсөгчдийн нэрс

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага	Албан тушаал

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

/албан бичгийг оруулах/

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо)

[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/

ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо)
..... [Магадлан итгэмжлэх комиссын
хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/